

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.06.05

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сард 1 удаа хуралдаж 8 асуудал хэлэлцэн 6 тогтоол баталлаа. Үүнд:

1."Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцын тухай аймгийн БОАЖГ-ын даргын мэдээлэл, "Сэлэнгэ төмс, хүнсний ногоо" хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай аймгийн ХХААГ-ын албаны даргын мэдээлэл, 2020 оны хаврын тариалалт, мал төллөлтийн байдлын талаарх аймгийн ХХААГ-ын мэдээллүүдийг сонслоо.

2.2020 онд Сэлэнгэ аймгаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг Мандал суманд 10, Зүүнбүрэн суманд 10, Баянгол суманд 5, Сант суманд 5 иргэн нийт 30 иргэн байхаар тогтоолоо.

3.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрээс 2020 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар бэлтгэх хэрэглээний болон түлээний модны нөөцөөс Сант суманд цэвэрлэгээний огтлолоор 820 шоо метр, Хүдэр суманд үйлдвэрлийн огтлолоор 2485 шоо метр, Түшиг суманд үйлдвэрлэлийн огтлолоор 1200 шоо метр, Мандал суманд үйлдвэрлэлийн огтлолоор 985 шоо метр, Баруунбүрэн суманд үйлдвэрлэлийн огтлолоор 610 шоо метрийг тус тус нэмж олголоо.

4.Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа христийн шашны "Мөнхийн шинэ чуулган", "Эзний улс чуулган" –уудын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг тус бүр 3 жилийн хугацаагаар сунгалаа.

5.Мал аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан хөдөлмөрийг нь үнэлж Сант сумын ахмад настан, мал зүйч Бэгзийн Батхүүг МУ-ын Гавьяат мал зүйч цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

6.Хяналт шалгалт, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 16 иргэнийг шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

7.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам"-ыг хүчингүй болгон, журмыг дахин боловсруулж Захиргааны ерөнхий хуулинд заасан бүрдлийг ханган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр тогтлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2020 оны эхний хагас жилийн ажлын үр дүн, Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж гаргасан бодлого шийдвэр, "Ковид-19" короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон аймгийн Засаг даргын "Сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2016 оны 05 тоот албан даалгаврын хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт бүрээр

шалгаж, үнэлэлт өгөх ажлыг зохион байгуулж байна. Энэ сард Мандал, Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн байгууллагуудыг хамруулж, үнэлэлт дүгнэлт өглөө.

АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Майкл С.Клечески тэргүүтэй төлөөлөгчид 5-р сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймагт албан айлчлал хийлээ. Төлөөлөгчдийг аймгийн Засаг дарга Ш.Оргил хүлээн авч уулзан харилцан санал солилцсон бөгөөд аймгийн “Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”, 2019 онд зохион байгуулсан аймгийн “Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт” үр дүнд Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг АНУ-ын элчин сайдын яамны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаатай газар дээр нь танилцсан. АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Майкл С.Клечески “Коронавирусын эрсдлээс улс үндэстнээ хамгаалж байгаа Монгол Улсын бодлого шийдвэр, цаашдын хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлж, ард иргэдэд үр өгөөжөө өгнө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу аймгийн хэмжээний төрийн албаны сул орон тоог нөхөх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж эхэлсэн. Энэ удаагийн шалгалтад нутгийн захиргааны 2 байгууллагын 11 албан тушаалын сул ажлын байрны тусгай шалгалт зарлагдаж 5 ажлын байранд 8 иргэн бүртгүүлж, албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан 5 иргэн шалгалтад оролцсон.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны хууль, эрхзүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, шагнал хариуцсан мэргэжилтэн, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэр, хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчин, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд бүртгүүлсэн төрийн албан хаагч болон төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс албан тушаалын тусгай (тухайн албан тушаалын) шалгалтыг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

2019 оны ажил үйлсээрээ орон нутаг, хамт олноо тэргүүлсэн аймгийн аварга хамт олон, салбарын аварга ажилтан, тэргүүний сурагч “Аварга тариаланч хамт олон”, “Аварга тариаланч”, “Аварга ногоочин”, “Аймгийн аварга малчин”, “Аварга фермер”, “Шилдэг хоршоо”, “Аймгийн шилдэг уяач”-ийг 2020 оны 2 дугаар сард шалгаруулан аймгийн Засаг даргын захирамжаар тодруулсан бөгөөд шагнал гардуулах ажлыг зохион байгууллаа.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар

Улсын Онцгой комиссын шийдвэрээр Оросын Холбооны Улсаас Монгол Улсын иргэдийг татан авах ажлыг зохион байгуулсан бөгөөд Алтанбулаг хилийн боомтоор 5 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд нийт 570 иргэнийг холбогдох журмын дагуу татан авч, тусгаарлалтанд шилжүүлээд байна.

Энэ сард Алтанбулаг хилийн боомтоор орж ирсэн тээврийн хэрэгслийн жолооч нараас тухай бүр шинжилгээ авч сорьцыг Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторид хүргүүлэн ажиллалаа. Мөн Оросын Холбооны Улсаас тээвэрлэгдэн ирсэн мод, үрийн будаа болон бусад бүтээгдэхүүнийг "Виду" ХХК "Сибир транс" ХХК, "Халиун Уул" ХХК, "Түмнийх хишиг" ХХК-ийн гаалийн хяналтын бүсэд буулгах явцад Цагдаагийн газар, Зооноз өвчин судлалын төв, Онцгой байдлын газар хамтран мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд энэ сарын эхээр тусгаарлалтад 26 иргэн байснаас өнөөдрийн байдлаар 10 иргэн байгаа бол ОХУ-аас 405 ачаа тээврийн том оврын автомашинуудыг ариутгал халдваргүйжүүлэлтэд хамруулан цагдаагийн байгууллагын хяналтан дор Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудад гүний

хяналтад шилжүүлсэн. Гэрийн ажиглалтад 52 иргэн байгаа бөгөөд Цагдаа, Онцгой байдлын газрын алба хаагчид хяналт тавин ажиллаж байна.

Хуурайшилтын зэрэг нэмэгдэж нэн аюултай түвшинд хүрсэнтэй холбогдуулан ой хээрт үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэг ажиллуулах тухай захирамжуудыг гаргуулан Байгаль орчин аюулал жуулчлалын газар, Цагдаагийн байгууллагын алба хаагчид эрсдэл өндөр бүхий сумдуудад 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн үүрэг гүйцэтгэж байна.

Сүхбаатар сумын Хонгорморьт 1-р багийн 12 айл өрхөд бага насны хүүхдийг хараа хяналтгүйгээр орхихгүй байх, ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж иргэдийн зөвшөөрлөөр гал түймэр гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан мэдэгдлийг хүргүүлж ажиллалаа.

Гол нуурын мөсөнд цөмрөх, эд хөрөнгө амь насаа алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж ярилцлагыг орон нутгийн хэвлэлийн байгууллагад өгч иргэдэд түгээсэн.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шар усны үер, хүчтэй цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжүүдийг sea.nema.gov.mn, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын page хуудас, аймгийн ЗДТГ-ын page хуудас, Сэлэнгэ зар зэрэг олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд түгээн ажилласан.

2020 оны 05 дугаар сард Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт аюулт үзэгдэл ослын 6 удаагийн дуудлага ирсний дагуу холбогдох арга хэмжээг авсан.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар

Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 5 сум 1 тосгонд хийж, нийт 1245 зөрчил дутагдлыг илрүүлж, 759 зөрчлийг арилгуулан, 1 аж ахуй нэгж, 5 иргэнд 2.900.000 төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч, 4.168.800 төгрөгийн нөхөн төлбөрийг тооцож, бүрэн барагдуулан ажиллалаа.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг, улсын төсвийн болон орон нутгийн төсөв хөрөнгөөр баригдаж буй барилга угсралтын үйл ажиллагаанд 4, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахад 1 аж ахуй нэгж байгууллагын 2 объект, автозамын чиглэлээр 3 аж ахуйн нэгж байгууллагад хийж, нийт 6 албан шаардлагыг хүргүүлэн хууль тогтоомжийн дагуу хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хушаат суманд гарсан зөвшөөрөлгүйгээр мод шилжүүлэн суулгасан, хууль бусаар загас агнасан зөрчилд зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

Мөн МХЕГ-ын даргын баталсан 2020 оны 01/85 тоот “Тандалт судалгаа хийх удирдамж”-ийн хүрээнд 11 сумын 32 мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжид нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS5368:2018 стандартын хэрэгжилт, үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай явуулах нөхцөлийг хангасан эсэх, мал эмнэлгийн ажил үйлчилгээнд тулгамдаж буй асуудалд үнэлгээг хийж, шилэн хяналтын цахим мэдээллийн санд бүртгэсэн байна.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Ээлжит баталгаажуулалтын ажлаар Сайхан, Баруунбүрэн, Сант, Мандал, Баянгол, Хүдэр, Ерөө, Цагааннуур, Шаамар сумын 67 аж ахуйн нэгжийн 70 гаруй үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 68 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон. Үүнд: хүнсний мухлаг 4, хүнсний дэлгүүр 36, минимаркет 10, худалдааны агуулах 1, цайны газар 4, кафе 1, ресторан 2, түргэн хоолны газар 1, караоке баар 4, дэн буудал 2, зочид буудал 2, үсчин 1 багтсан байна.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Сайхан сумын “Ханк” ХХК-ий хагас боловсруулсан махан бүтээгдэхүүний цехэд үйлдвэрлэсэн 3 нэрийн 8 бүтээгдэхүүн, Цагааннуур сумын “Уран цацал” ХХК-ий үйлдвэрлэсэн 1 нэрийн 1 бүтээгдэхүүнийг МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт гаргасан. Цагааннуур сумын “Усан болор” ХХК-ий “Усан болор” талхан цехийн 2 төрлийн талх, 1 төрлийн нарийн боовонд тохирлын гэрчилгээ олгож ажиллалаа.

Стандартын салбар сан:

Салбар сангаас 15 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 3 нэрийн 15 стандартын борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хилийн Мэргэжлийн хяналтын албаны Алтанбулаг боомтын лабораторийн захиалгын дагуу 23 стандартад шүүлт хийсэн.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр 60 шатахуун түгээх газрын 200 ширхэг шатахуун түгээгүүрийн шингэн хэмжигчийг, механикийн хэмжлийн төрлөөр худалдаа, үйлчилгээ, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 162 ширхэг жинг шалган, ээлжит баталгаажуулалтад хамруулсан байна.

Цахилгааны хэмжлийн төрлөөр Жавхлант сум болон Сүхбаатар салбарын Төмөр замын хэрэглэгчдийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 фазын 348 ш, 3 фазын 84 ш цахилгааны тоолуурыг шалган баталгаажуулсан. Нийт 432ш тоолуур баталгаажуулалтад хамруулан ажилласан байна.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 6 ширхэг термометрийг шалган баталгаажуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 9/1579 тоот албан бичгийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 13-19-ний өдрүүдэд Сүхбаатар, Мандал, Цагааннуур, Сайхан, Ерөө, Баянгол сумдад үйл ажиллагаа явуулж буй “Гялс төгрөг” хадгаламж зээлийн хоршооны салбаруудад хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Аймгийн хэмжээнд нийт 3 Хадгаламж, зээлийн хоршоо Татварын хэлтэст бүртгэлтэй байна.

Татвар төлөгчдийн өдрүүд арга хэмжээг Улсын хэмжээнд 21 дэх жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд 2020 онд “Эрсдлийн эсрэг хамдаа” уриан дор 05 дугаар сарын 04-нөөс 08-ны өдрүүдэд цахимаар зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 1000 гаруй татвар төлөгч хамрагдаж, аймаг, сумдын нийт 52 байцаагч, 4000 гаруй фэйсбүүк дагагч үзэж, 126 шэйр, 1246 лайк дарсан байна. Татварын албанаас цахим татварын системд байршуулсан [#Би_Татвараа_цахимаар_төлсөн](#) чөлэнжэд нийт 326 татвар төлөгчдийг хамруулсан. Шилдэг татвар төлөгчөөр шалгарсан 26 иргэн, аж ахуйн нэгжид татвар төлөгчийн “ТАЛАРХАЛ”-ыг гардуулсан. “Цахим ертөнц” ХХК, “Уулын нуур” ХХК, иргэн Ц.Алтанцэцэг нарыг шилдэг татвар төлөгчөөр шалгаруулж тэдгээрийн үйл ажиллагааг сурталчилан цахим хуудсанд байршуулсан. Авто тээврийн хэрэгслийн татвараа хэрхэн цахимаар төлөх тухай зааварыг 3000 ширхэгийг хэвлүүлж 17 сум 5 тосгоны 2850 татвар төлөгчдийг гарын авлагаар хангаж ажиллалаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар: /4-р сарын гүйцэтгэлээр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	36,128,991.9	30,839,448.4	85.4
1.1	Орон нутгийн төсвийн орлого	8,554,077.7	6,986,210.6	81,7
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	6,647,862.3	5,294,254.1	79.6
	Сумдын төсвийн орлого	1,906,215.4	1,691,956.5	88.8
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2,510,666.4	2,510,666.4	100.0

1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	20,275,661.3	18,293,996.7	90.2
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	1,658,385.3	1,146,333.5	69.1
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,600,526.5	1,600,526.5	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	301,714.7	301,714.7	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,227,960.0	304,934.5	24.8
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		37,030,378.2	26,438,204.0	71.4
Орон нутгийн төсвийн нийт зарлага		37,030,378.2	26,438,204.0	71.4
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		7,449,100.1	5,087,474.4	68.3
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		301,666.4	80,590.0	26.7
Сумдын сум хөгжүүлэх сан		6,165,392.9	3,056,642.0	49.6
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		4,621,819.1	2,320,201.0	50.2
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		1,105,088.8	189,857.6	17.2
2.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1,611,271.3	447,256.2	27.8
Халамжийн сан		126,557.5	54,200.0	42.8
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		3,100,123.9	2,145,333.8	69.2
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		222,351.4	219,994.4	98.9
Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		23,114,218.8	18,213,497.5	78.8
Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		424,101.9	360,646.8	85.0
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		26,501,684.7	23,546,548.8	88.8
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,982,181.0	4,106,218.6	82.4
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		47,114.0	636,306.4	1350.6
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	47,114.0	47,114.0	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд		-	-	
Хөрөнгө оруулалтын зардалд		-	589,192.4	
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		1,196,728.4	510,027.1	42.6
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1,158,123.4	471,422.1	40.7
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		38,605.0	38,605.0	
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	19,886,085.0	17,905,016.7	90.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	389,576.3	388,980.0	99.8
Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/		20,275,661.3	18,293,996.7	90.2
- Ерөнхий боловсролын сургууль		10,819,126.7	10,007,427.2	92.5
- Хүүхдийн цэцэрлэг		6,385,938.1	5,046,658.9	79.0
- Эрүүл мэндийн байгууллага		2,629,367.7	2,629,367.7	100.0
- Газрын кадастрын байгууллага		225,485.6	225,485.6	100.0
- Хүүхдийн байгууллага		215,743.2	215,146.9	99.7
4. Тусгай сангуудын зарлага		1,227,960.0	304,934.5	24.8
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,227,960.0	304,934.5	24.8

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2019 04- сар	2020 04- сар	2020- 04 2019-04 /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			

1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 200	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 500	104.2
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	8 500	130.8
	Үхрийн мах /кг/	8 300	9 500	114.5
	Адууны мах /кг/	7000	7 500	107.1
	Ямааны мах /кг/	6 000	7 500	125.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 800	1 800	100.0
	Сүү / савласан, л/	2 600	3000	115.4
	Тараг /задгай, л/	2 000	2 000	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	4 200	110.5
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 000	100.0
	Лууван /кг/	1200	1 200	100.0
	Манжин /кг/	1200	1500	125.0
	Байцаа /кг/	1500	1200	80.0
	Сонгино /кг/	1500	1800	120.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 200	120.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 680	102.1
	Бензин А - 92	1 725	1 780	103.2
	Дизелийн түлш	2 275	2 470	108.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 4 сард 143 холбогдогчтой 475,7 сая төгрөгийн хохиролтой, 226 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 56-аар буюу 19,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 39,5 хувьтай байгаа нь өмнөх оноос 6.7 хувиар өссөн байна. 6471 зөрчил илрүүлсэн нь 3012 зөрчлөөр буюу 31,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 05 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 132, лавлагаа 8, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 366, лавлагаа 3 олгож үйлчиллээ.

Иргэний бүртгэлийн чиглэлээр

- ✓ Төрсний бүртгэл – 216 /эрэгтэй-121, эмэгтэй-95/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 48
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 12
- ✓ Үрчлэлт - 10

- ✓ Эцэг тогтоолт – 5
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 11
- ✓ Нас баралт – 62
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 520
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 151
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 116
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 253
- ✓ Гадаад паспорт олголт – 19 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын талаар

Монгол Улсын Засгийн газраас шинэ төрлийн КОВИД-19 вирусын тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан халдварын тархалтаас сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, хорио цээрийн дэглэм тогтоож, ажилтан, албан хаагчдын ажлын цагийг богиносгох, гэрээсээ ажиллах, бөөгнөрөл үүсгэхгүй байх шийдвэрийг хэрэгжүүлж, боловсролын байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, барилга, байгууламжийн орчны хяналт суларч болзошгүй байгааг харгалзан ажилтан, албан хаагчдын сонор сэрэмжийг дээшлүүлэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийн тайлан, мэдээг авч нэгтгэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл урлагийн бодлогын зохицуулалтын газарт 05 дугаар сарын 20-нд хүргүүлсэн.

2020 оны 05 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Бэлчир, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Орхон бүсүүдэд “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, 2020 онд шилжих болон шинээр батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын явцад зөвлөн туслах, хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, хөл хорио тогтоосон хугацаанд багш, сурагчдад өгч байгаа ажлын чиглэл, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэж байгаа сурагчдын давтлага зохион байгуулж байгаа нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, багш, удирдах ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ ОНХ-тэй хамтран “Шүд болон гараа дарааллын дагуу хэн хамгийн сайн зөв угааж сурсан бэ?” бүсийн аварга шалгаруулах цахим уралдааныг Сүхбаатар, Орхон, Сант, Жавхлант, Хүдэр, Ерөө, Шаамар сум, Дулаанхаан, Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын А/99 тоот захирамжийг хэрэгжүүлэн хөл хорио тогтоосон энэ өдрүүдэд иргэдийг биеийн тамир, спортоор идэвхтэй хичээллүүлэн гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох, дасгал хөдөлгөөнөө хамтдаа сурч хөгжилдөх, амьдралдаа хэвшүүлэн дархлаагаа сэргээн дэмжин сайжруулах зорилгоор “Дасгалаар дархлаагаа дэмжье” сарын аяныг аймгийн Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ “Цахим телевиз” хамтран сарын хугацаатай зохион байгуулсан. Идэвхтэй хөдөлгөөн хийх гарын авлага тараах материал, зөвлөмжийг 38 байгууллага, аж ахуй нэгжийн нийт 1140 албан хаагч, мөн Мандал, Цагааннуур, Ерөө, Сайхан, Баруунбүрэн, Баянгол сум Дулаанхан тосгоны спортын цогцолбор клубуудыг хамруулсан.

Аяны хүрээнд насны ангилалаар гар зургийн уралдааныг зохион байгуулсан бөгөөд “Миний дуртай спорт” сэдвийн хүрээнд 1-5 ангийн сурагчдын дунд, гимнастикийн дасгал 6-8 ангийн сурагчдын дунд, хүчний дасгал 9-12 ангийн сурагчдын дунд, гэр бүл хамтдаа хийх дасгал зэрэг чиглэлээр зохион байгуулж аянд нийт 151 хүүхэд, гэр бүл хамрагдсан.

2.Эрүүл мэндийн талаар:

Аймгийн хэмжээнд нийт 348 иргэн тусгаарлан ажиглалтанд авснаас 5-р сард 14 иргэн тусгаарлалтанд авсан. Сүхбаатар сумын ахмадын сувилалд 6, АНЭ-ийн халдвартын тасагт 8 иргэнийг байна. Тусгаарланд хүүхэд 4, жирэмсэн 1 байна. 2020 оны 05-р сарын 14, 15-ны өдрүүдэд ОХУ-аас нийт 393 иргэнийг татан авч Орхон, Дархан-уул, Төв аймаг, Сэлэнгэ аймагт тус тус тусгаарласан. Үүнд 1 эмч, 1 сувилагч, 2 үйлчилгээний ажилтан дамжин өнгөрүүлэх байранд 4 эмнэлгийн мэргэжилтэн тус тус ажилласан байна. 94 байгууллага, 3182 хүнд сургалт сурталчилгаа хийж 2656 гарын авлага, материал тараасан. 210 байгууллага, аж ахуйн нэгжийн 80644,8 метр квадрат талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 12076 хүнд духны халуун хэмжигчээр халууныг үзсэн халуурсан хүн байгаагүй. Урьдчилан сэргийлэх 606 мэдээллийг цахим орчинд байршуулж, 11366 иргэдэд онлайнаар мэдээлэл, зөвлөгөө хүргэсэн хандалттай байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 35.1, 35.3, Гамшгаас хамгаалах хуулийн 10.4.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 03 дугаар сарын 13-ны А/175 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 02 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэд штаб хариу арга хэмжээг зохион байгуулах багийг томилж Эрүүл мэндийн газрын “Эрдмийн жим” сургалтын өрөөнд Ковид-19 цар тахлын, дадлага сургуулалтын бэлэн байдлыг ханган ажилласан.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2020 оны 5-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 579 байсан бол 276 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 62 ажлын байранд 47 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 444 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 411 болсон байна.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-үүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлаар дэмжигдсэн 65 иргэнтэй холбогдох гэрээг байгуулан 168500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Шаамар, Сайхан, Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Мандал, Баянгол, Алтанбулаг, Хушаат сумдад бэлчээрийн үлийн цагаан оготно устгах ажлыг зохион байгуулж орон нутгийн бүртгэлтэй ажилгүй 110 иргэнийг 7 хоногийн хугацаатай ажиллуулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 21560.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Нийгмийн халамжийн сангаас 5 сарын байдлаар 33309 иргэнд 4,499,013.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2303 иргэнд 1,245,583.2 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1581 иргэнд 359,900.5 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1535 иргэнд 211,834.1 мянган төгрөг
- Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 9 иргэнд 10,800.0 мянган төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмжинд 5 иргэнд 10,000.0 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 1942 иргэнд 78,669.9 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 208 иргэнд 19,616.1 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 1151 эхэд 87,157.4 мянган төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 72 иргэнд 26,490.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8672 иргэнд 1,128,300.0 мянган төгрөг
- Насны хишиг 4768 иргэнд 373,150.0 төгрөг
- “Цалинтай ээж” хөтөлбөрт 5292 иргэнд 676,235.3 мянган төгрөг

- Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 173 иргэнд 70,943.1 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 5598 иргэд 200,333.4 мянган төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөл хөтөлбөрт 44 өрх 26,500,000 төгрөгийг олгосон.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 15 дуудлага мэдээллийг хүлээн авч хамтарсан багт шилжүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Дуудлагыг агуулгаар нь ангилахад сэтгэл санааны хүчирхийлэл 8, үл хайхрах хүчирхийлэл 5, бие махбодын хүчирхийлэл 2 байна. Цагдаагийн газарт шалгагдаж байгаа эрүүгийн 2 хэрэгт 3 мэргэжилтэн, 1 сэтгэлзүйч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажилласан.

“Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоо, үнэт зүйлсийг бэхжүүлэх, гэр бүлээрээ хамтдаа өнгөрүүлэх дурсамжийг бүтээлцэх, бат бэх тогтвортой байдлыг хангах зорилгоор “Гэр бүлийн өдрийн зоог” цахим уралдааныг зохион байгуулж уралдаанд 8 гэр бүлийн 19 гишүүд, 8 төрлийн хоол зуушыг бэлтгэн гэр бүлийн гишүүдийн хамтаар оролцож, хамгийн их “like” цуглуулсан гэр бүлийн видеог шалгаруулж, эхний 1, 2 дугаар байранд шалгарсан гэр бүлийг өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ ОНХХ-ийн хүрээнд Европын холбооны төсөлд хохирогч 2 хүүхдийн талаарх мэдээллийг хүргүүлж цаашид уг төсөлтэй хамтран ажиллахаар болсон.

Залуучуудын хөгжлийн тухай хууль, Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг “Сэлэнгэ гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар”, “Сэлэнгэ хүүхэд”, “Сэлэнгэ залуучуудын хөгжлийн төв” гэсэн пэйж цахим хуудсаар олон нийтэд сурталчлан таниулж ажиллалаа.

5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын хэлтсээс 2020 оны 05 дугаар сарын байдлаар 14,2 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 05 дугаар сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 12,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 88,6 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17328 тэтгэвэр авагчдад 26,214,878 мянган төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 2184 хүнд 1,134,154 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 218 хүнд 386,215 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 152 хүнд 409,364 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг 2020 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар 625 лавлагааг иргэд, аж ахуй нэгжид цахим болон цаасан хэлбэрээр гарган түргэн шуурхай үйлчлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”, НДЕГ-ын даргын А/08 тоот тушаалаар баталсан “Малчин, даатгуулагч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг хэрэгжүүлэх заавар”-ыг сумдын байцаагчдад хүргүүлж, 92 малчин иргэний хүсэлтийг хүлээн авснаас 23 малчин, 2 хувиар хөдөлмөр эрхлэгч нийт 25 иргэний нөхөн даатгалыг баталгаажуулсан.

Мөн МУЗГ-ын 140 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын хэрэгжилтийг зохион байгуулах

ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн хэмжээнд 750 аж ахуй нэгж байгууллагын судалгааг гарган Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 5 дугаар сард 3 хуралдаж, 380 иргэн хурлаар орж, 303 иргэний актыг сунгаж, 56 иргэн шинээр тогтоож, 21 иргэний актыг цуцалсан байна.

Тав.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд

1.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний талаар

Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлж буй “Атар IV” аяны хэрэгжилтийг эрчимжүүлэх, хаврын тариалалтын бэлтгэлийг хангаж технологийн дагуу шуурхай зохион байгуулах зорилгоор 7 хоног бүр зохион байгуулсан ажил, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг сумаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Хаврын тариалалтанд нийт 731 зүтгэх хүчний трактор, 712 үрлүүр, 1138 борной, 313 сийрүүлэгч, 54 сэндэчлэгч, 179 анжис ажиллаж байна. Мөн хаврын тариалалтын хүн хүчний судалгаагаар 81 инженер, 110 агрономич, 36 агротехникч, 74 механикч, 20 токарчин, 10 усны инженер, 550 механикжуулагч ажиллаж байна. 2020 оны хаврын тариалалтанд нийт 21300 тонн үр шаардагдахаас 17966,30 үрийг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид маань өөрсдөө үрээ нөөцөлж, дутагдаж байсан 5985,70 тонн үрийн захиалгыг ХХААХҮЯ, ХААДС-нд санал хүргүүлснээр Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын үрийн нөөцийн газраар дамжуулан дутагдаж байгаа үрийг олгоод байна.

Мөн төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдаас Сэлэнгэ аймагт эрх шилжиж ирсэн “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 37 тн төмс, 150 кг лууван, 100 кг шар манжин, 100 кг хүрэн манжин, 200 кг сармисыг 17 суманд олгосон.

Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын “Best” хөтөлбөртэй хамтран “Төсөл хэрхэн бичих вэ, Зээлийн боловсрол” сургалтыг зохион байгуулж, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн журмын танилцуулгыг 17 сумын нийт 232 иргэдэд мэдээлэн ажилласан.

Мал төллөлт төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг сумдаас гаргуулан авч нэгтгэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 788735 толгой хээлтэгч мал төллөхөөс 609307 толгой мал төллөсөн. Үүнээс ингэ 63, гүү-18511, Үхэр-60145, эм хонь 298847, эм ямаа-235930 төллөж, мал төллөлт 77.2 хувьтай, төл бойжилт 99,6 хувьтай байна. Төлийн хорогдол 2254, том малын зүй бус хорогдол 1435 байна.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг ажиллуулах талаар МЭЕГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт мал эмнэлгийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээлэл, бүртгэлмэдээллийгоруулахталаар заавар, зөвлөгөө өгч мал эмнэлгийн нэгдсэн системээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Энэ сард цахим гэрчилгээгээр адуу 444, үхэр 625, тэмээ 30, хонь 3945, ямаа 2473 гахай 35, тахиа 28 бүгд 7580 толгой мал амьтан, мах 32888 кг, цувдаа 252 кг, толгой 141 ш, бууз 200 кг, өндөг 14 бүгд мах махан бүтээгдэхүүн 33495 кг, сүү 94066 л, ааруул 1971 кг, тараг 300 кл, нийт сүү сүүн бүтээгдэхүүн 96337кг, арьс шир 156 ш, өлөн 50 ш, ноолуур 8821 кг нийт түүхий эд 9027 ш/кг тус тус мал эмнэлгийн нэгдсэн системээр мал эмнэлгийн гэрчилгээ олгож баталгаажууллаа.

Өөр аймаг сумруу шилжин явсан адуу 348, үхэр 355, хонь 414, ямаа 601 тахиа 28 нийт 1746 толгой мал амьтан шилжин явсан. Үүнээс Отроор адуу 39, үхэр 85, хонь 317 ямаа 212, бүгд 653 толгой, үзэсгэлэн, уралдаанд адуу 13, хонь 26, бүгд 39 толгой, үржилээр адуу 296, үхэр 270, хонь 71, ямаа 389, тахиа 28 бүгд 1054 толгой мал амьтан тус тус шилжин явсан.

Өөр аймаг сумаас шилжин ирсэн адуу 293, үхэр 222, хонь 222, ямаа 330, гахай 6, нохой 1 нийт 1076 толгой мал амьтан шилжин ирсэн. Үүнээс отроор адуу 181, үхэр 151, хонь 204, ямаа 223, бүгд 761 толгой, үзэсгэлэн уралдаанд адуу 24, толгой, үржилээр адуу 88, үхэр 71, хонь 18, ямаа 107, гахай 6, нохой 1 бүгд 291 толгой мал амьтан тус тус шилжин ирсэн.

Малчин мал бүхий иргэдэд малчин өрхийн мал амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэрийг 85 хувиар ханган заавар журмын дагуу хөтөлж хэвшсэн байна.

2. Байгаль орчны талаар

Бүх нийтээр мод тарих өдрөөр “Өрх бүр хашаандаа 2 мод тарья” уриалга гаргаж байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан. Мөн Сүхбаатар самбар дээр “Өрх бүр хашаандаа 2 мод тарья” уриалга бүхий самбар байршуулсан. Мод тарих хялбаршуулсан гарын авлага, уриалга бүхий тараах материалыг бүх сумдад хүргүүлэн ажилласан. Аймгийн төв Сүхбаатар суманд шинээр байгуулсан “Ногоон төгөл”-д хайлаас 200 ширхэг, шинэс 20 ширхэг, гацуур 10 ширхэг, голт бор 76 ширхэгийг тус тус тарьсан.

Сумдын Засаг дарга нарт 2021 онд бэлтгэх модны саналыг холбогдох журмын дагуу ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлж саналыг нэгтгэн ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газрын Экологийн цагдаа нартай хамтран хууль бусаар ан амьтан агнах, барих үйлдлийг таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар сумын “Олон улсын худалдааны төв”-д утсан загас худалддаг иргэдтэй уулзаж борлуулж буй загасны холбогдох бичиг баримтуудыг шалгаж, 30 гаруй иргэнд хууль тогтоомжуудыг сурталчилан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн Экологийн цагдаа нартай хамтран хяналт шалгалт явуулахад Сүхбаатар сумын 1-р баг Хонгор морьтод хууль бусаар 100 гаруй загас барьсан иргэнийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах сургалт сурталчилгаа, хяналт шалгалт хийх ажлын удирдамжийг тус газрын дарга болон ОБГ-ын дарга нараар батлуулсан. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас COVID-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх, түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, сум орон нутгийн иргэн бүрт хүргэх зорилгоор сум орон нутагт ажиллаж буй байгаль хамгаалагч бүрт 40000 төгрөгийн шатахууны талон, санамж хуудас 80 ширхэг буюу нийт 1600 000 төгрөгийн шатахууны талон, 2000 ширхэг санамж хуудас, зөвлөгөө өгч санамж хуудас олгосон тэмдэглэл хөтлөх 400 хүний нэрс багтах 10 ширхэг хуудсыг тус газраас олгож тайланг 6 дугаар сарын 5-нд авахаар төлөвлөсөн.

Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ аяны хүрээнд 2020 оны “Дахивар хаягдал нягтруулан шахах төхөөрөмж суурилуулах” ажлын гэрээг Сан-Оргиу ХХК-тай байгуулан ажилласан. “Дахивар хаягдал нягтруулан шахах төхөөрөмж”, 10 боодол зориулалтын төмөр утас, 100х300 хэмжээтэй 1 ширхэг ангилдаг хогийн сав, Хог хаягдлын гарын авлага тараах материал 500 ширхэг, цахим орчинд 2 төрлийн шторк хийх, орон нутгийн ТВ-гээр нэвтрүүлэг хийлгэх ажлуудыг хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. “Эксодус пикчерс” ХХК-тай гэрээ байгуулан 2 шторк, 1 захиалгат нэвтрүүлэг хийж “facebook” хуудсаар мэдээллийг тухай бүр түгээж ажиллалаа.

3. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар

Тайлант сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шинээр газар эзэмших хүсэлт гаргасан 15, газар эзэмших эрхээ гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 30, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 2, эрхийн гэрчилгээ гээгдүүлсэн үрэгдүүлсэн 4, газар өмчлөгч иргэдээс дундын өмчлөлөө салгуулж, өмчлөх эрх нээлгэх хүсэлт гаргасан 3 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авч аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар газар эзэмших эрхийг шилжүүлж, шинээр эзэмшүүлсэн. Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт,

боловсруулалт хийлгэсэн 25 нэгж талбарын кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан. Мөн Сүхбаатар сумын 32 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд 5-р сард дараах барилга угсралт болон засвар шинэчлэлийн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Газрын харилцааны ажилтны өдрийг угтан хот байгуулалтын кадастрын мэдээлэлийн сан байгуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах удирдамжийн хүрээнд хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 673652018 стандартын дагуу хөрвүүлсэн, Сүхбаатар, Цагааннуур сумдын хот төлөвлөлтийн давхаргуудыг зориулалт, ангиллын дагуу SHAPEFILE болгон хөрвүүлж хугацаанд нь хүргүүлсэн.

Covid-19 вирусээс урьдчилан сэргийлж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас цахим сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон сумын газрын даамлууд хамрагдаж ZY-3 хиймэл дагуулын 2.1 метрийн нарийвчлалтай панхроматик, үзэгдэх гэрлийн 5.8 метрийн нарийвчлалтай уг сансрын зургийг боловсруулах, үйл ажиллагаандаа хэрэглэх чиглэлээр цахим сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 12-ний өдөр зохион байгууллаа.

4.Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар

Аймгийн орон нутгийн өмчит байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тайлангаар барилга байгууламж 205,120,243,507 төгрөг, тээврийн хэрэгсэл 9,948,005,851 төгрөг, машин тоног төхөөрөмж 25,528,111,444 төгрөг, номын фонд 1,278,228,390 төгрөг, биет бус хөрөнгө 20,089,850,112 төгрөг, үнэт зүйл 2,031,955,910 төгрөг, дуусаагүй барилга 4,754,740,754 төгрөг, бусад үндсэн хөрөнгө 29,329,854,921 төгрөг байсан. Үүнийг удирдлагыг мэдээлэлжүүлэх цахим системд шивж оруулах зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд ажлын явц 65 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумдын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д оруулахад хяналт тавьж ажиллаж байна. Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 20-ны дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг баталгаажуулж ажиллалаа.

Тендерийг 100 хувь цахимаар зохион байгуулан ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөнз ахирагчийн 2020 оны төлөвлөгөөнд нийт 138 ажил батлагдснаас гэрээ байгуулах эрх олгосон 75, тендер хүлээн авах шатандаа 26, үнэлгээ хийж байгаа 18, зураг төсөв ирүүлээгүй 19 ажил байна.

Зургаа.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сангаас зээл олгох асуудлаар “Төсөл хэрхэн бичих вэ? Сургалтыг зохион байгуулж, 15 хүн хамрагдсан. Тус сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтээ 8 аж ахуйн нэгж төслөө хүргүүлээд байна.

Сумын хаврын тариалалтын явц 65 хувьтай байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын постыг ажилуулж байгаа бөгөөд нийт 4 албан хаагч үүрэг гүйцэтгэж, 50 иргэнд ойн тухай хууль тогтоомж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Бүх нийтээр мод тарих ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж, “Өрх бүр-хоёр мод” уриан дор явуулж, 30 өрх 206 ширхэг мод, төр төсвийн болон байгууллага аж ахуйн нэгжүүд 283 ширхэг мод бут сөөгийг тарьсан.

Энэ онд 12 дугаар анги төгсөгчдийг ЭЕШ-д бэлтгэх ажлын хүрээнд багш сурагчдад мэдээлэл өгөх, харилцан туршлага судлах онлайн хурлыг 2 өдөр зохион байгуулсан. Төгсөх ангийн сурагчдад давтлага өгөх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, анги бүрт 10 сурагч байхаар 4 танхимын бэлтгэж, ариутгал цэвэрлэгээ хийж, байна. Давлагад 42 суралцагч хамрагдаж байна. Мөн “Цахим сорилго-2020” онлайн шалгалтанд 9 хичээлээр 42 сурагч хамрагдсан.

Суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй эрүүл мэндийн төвийн их засварын ажил 5 дугаар сарын 20-оос эхлээд байна.

Баруунбүрэн сум:

Хаврын тариалалтын ажил эхэлж, 2020 оны 05-р сарын 20-ны өдрийн байдлаар 3000 га талбайд үр тариа, 85 га талбайд төмс, 76,9 га талбайд хүнсний ногоо тариалаад байна.

Бэлчээрийн оготно устгалын ажлын хүрээнд Бэлчээрт тархсан хортон мэрэгчидтэй хийх тэмцлийн ажлыг зохион байгуулах тухай сумын Засаг даргын 2020 оны 05-р сарын 06-ны өдрийн А/87 тоот захирамжийг гарган хавсралтаар устгал хийх газрын нэр, ажиллагсдын нэр батлуулан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс ажиллах иргэдийн цалин хөлсийг өдрийн 28000 төгрөгөөр тооцон 7 хоног 20 иргэнийг ажиллууллаа. Мөн шатахууны зардлыг “Өрнөлт сэлэнгэ” ХХК гаргаж оготно устгалын ажлыг чанартай хийж гүйцэтгэлээ.

Мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа 2 нэгжид ирсэн дуудлага, үзлэг тандалт, цахим бүртгэлийн нэгдсэн системд бичигдсэн гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээ мэдээллийг Мал эмнэлгийн газар болон сумын Онцгой комиссын шуурхай штабт өдөр бүр хүргэн ажиллаж байна. Сумын малчидаар явж, аймгийн Засаг даргын 09 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн газрын даргын 42 тоот, сумын Засаг даргын А/47, А/55 тоот захирамж, мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон дагалдан гарсан заавар журамыг 25 өрхөд танилцуулж малын өрхийн эрүүл мэндийн дэвтэрт хяналт тавьж ажилласан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын даргын баталсан 2020 оны 01 сарын 10-ны өдрийн 02 тоот удирдамжийн дагуу шалгах явцад гарсан зөрчлийн дагуу Өгөөмөрт хаваржиж байсан Наранцэцэг овогтой Отгонбаатарын 14 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоож, Бүрэнсүрэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр үхэрт туулгалт, хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэн хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласан.

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторт бруцеллөз өвчний шинжилгээнд 70 толгой үхрийн цуснаас дээж авч өгч явуулан хариуг авч эзэнд нь танилцуулж мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгсөн

“Хандлагаа өөрчилъе” багц ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй “Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ” аяныг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулж байгаа билээ. Энэхүү аяны хүрээнд тус сум нь Ивэнгийн 1-р багийн Цагаан хөтөл, Хүжийн гол, Дарь-эх толгой, Тойлбын хошуу, Ивэн голын сав газруудын хогийг 1-р багийн Засаг дарга, байгаль хамгаалагч, 1-р цэцэрлэгийн хамт олон, иргэд, малчид, Амарбаясгалант хийдийн лам нар гэсэн нийт 54 хүний оролцоотойгоор 5-р сарын 19-ний өдөр хог хаягдлыг цэвэрлэж 12 машин хогийг хогийн нэгдсэн цэгт тээвэрлэн устгаж ажиллалаа.

Мөн сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид хамтран Бургалтайн гол, гүүрний дагуух хог хаягдлыг цэвэрлэж, байгууллагын ойр орчмын 50 м газрыг цэвэрлэх арга хэмжээ авлаа.

Тайлант сард сумын Эрүүл мэндийн төвд 05 дугаар сарын байдлаар амбулаторийн үзлэг-226, урьдчилан сэргийлэх үзлэг- 204, осол гэмтлийн өвчлөл-4, эмнэлэгт хэвтсэн-19, шинжилгээнд 172 хүн хамрагдсан.

Шинэ коронавирусын үед хэрэглэгдэх яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, нэг удаагийн хамгаалах хувцах хэрэгсэл, амны хаалтныг эмнэлгийн ажилчид хүн бүрт 3-5 удаагийн хүрэлцэхүйц хэмжээний нөөц, түргэн тусламжийн машин шатахууны нөөц, орны нөөцийг бэлдэн ажиллаж байна. Энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг өдөр бүр цахим орчинд тавьж ард иргэдэд гарын авлага, боршуур 80 нэр төрлийн 600 ш хэвлэж ард иргэд болон үйлчлүүлэгчдэд өдөр бүр тарааж мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол хийж байна. Ариутгал халдваргүйтгэлийн баг нь өдөр бүр аж ахуй нэгж болон албан байгууллагаар ариутгал халдваргүйтгэл, сургалт сургалчилгаа хийж гарын авлага боршуур тарааж нийт 410 хүнийг хамруулж 900 ш гарын авлага тараасан.

Хорио цээрийн дэглэмийн хугацаанд эргүүл жижүүрийн үүргийг сургууль, цэцэрлэгийн байгууллагаас тогтмол зохион байгуулж байна. Бага ангийн 270 суралцагч, суурь 70, ахлах ангийн 83 суралцагчтай байнгын эргэх холбоотой ажиллаж байна.

Боловсрол соёл урлагийн газраас зохион явуулсан цахим хуралд 2 удирдах ажилтан, 16 багш хамрагдсан. Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх зорилгоор 2020 оны 05-р сарын 11-ний өдрөөс эхлэн 12-р ангийн 21 суралцагчдад 10 хичээлээр нийт 48 цагийн давтлагыг өгөөд байна. Давтлаганд ирж байгаа суралцагчид болон багш, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс сургуулийн урд талд ариутгалын цэг, халуун хэмжих цэгийг байрлуулан багш, сурагчид, ажилчдын халууныг тогтмол хэмжин бүртгэл хөтөлж байна. Мөн нэг удаагийн бээлий, амны хаалт, гар ариутгагч, ариутгалын бодисыг 1134950 төгрөгөөр худалдан авсан.

Цахим орчинд дархлаа дэмжих дасгал болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, спорттой холбоотой цуврал хичээл, танин мэдэхүйн мэдээ мэдээлэл нийт 39 оруулж иргэдэд цахимаар хүргэж ажиллалаа.

Баянгол сум:

Тус сумаас Улсын аварга тариаланчаар Баян багийн ногоочин Б.Энхцэцэг, Улсын аварга малчнаар Хараа багийн малчин Н.Отгондорж, аймгийн аварга тариаланч хамт олноор Баяншинэ зам ХХК, аймгийн аварга малчнаар Хараа багийн малчин Б.Ядамжав, Баян багийн малчин Г.Сэнгэдорж нар шалгарч 05 дугаар сарын 09, 21-нд тус тус шагналаа гардаж авлаа.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас кибер халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор авч буй судалгаанд тус сумын төрийн байгууллагуудыг www.cabinet.gov.mn/sudalгаа.html хаягаар хандан бүрэн хамруулсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дүгээр сарын 06-ны өдрийн А/136 тоот “Цагийн хязгаарлалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийг сумын нутаг дэвсгэрт “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилдэг тусгай зөвшөөрөл”-тэй худалдаа, үйлчилгээний 14 аж ахуйн нэгж байгууллага 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл өглөөний 10:00 цагаас оройн 22:00 цаг хүртэл архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тухай захирамжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан Цагдаагийн хэсэг хяналт тавин ажиллаж байна.

Бэлчээрийн талбайн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх ажлыг Хараа багийн Доргонт хустай, Баянгол, Үзүүр улаан, Загдал, Мангирт, угалзын хоолой, Баян багийн Төмөрт, Банк, Чойжин, Барчгар, Зандан, Адуун чулуу Гонир багийн Нарийн хөндий, Манхтай, Зараа толгой, Чандагатай, Цагаанчулуун зэрэг газрын 9900 га талбайд 2020 оны 05 сарын 04-11 хооронд 7 хоног сумын зорилтот бүлгийн 10 иргэн, 8 техник эзэмшигч, 26 малчин оролцуулан ажлын хэсгийн гишүүд ахлан 8 хээрийн ажлын бүлэгтэй гэрээ хийн оготоно устгалын ажлыг хийж, нийт 50 иргэн 8 бага оврын ачааны машин, 6 суудлын машинтайгаар ажиллаж гэрээнд заасны дагуу 102 тн ус цутган, 500 ширхэг шувууны суудал хийн үүрийг эвдэх сэндийсэх, утах зэрэг байгальд халгүй арга технологиор хийж гүйцэтгэсэн.

МЭҮН-үүд 5 сард 314 толгой мал, 4845 кг мах, 20 ширхэг толгой, 2850 л сүүнд цахим гэрчилгээ бичиж 9213,2 м² талбайдхалдваргүйжүүлэлт хийсэн ба 124386 толгой мал амьтан урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулхаас 94760 толгой малд вакцинжуулалт хийн 76,2%-тай явагдаж байна.

МЭҮН-үүд хариуцсан нутаг дэвсгэрийн дайран өнгөрөх төв зам дагуух болон газар нутагт байх сэг зэмийг булж устган 7250 м² нийтийн эзэмшлийн талбайд ариутгал хийсэн.

Ой, хээрийн түймэр гарч болзошгүй эрсдэл өндөртэй Баян багийн Нарангийн ам гэх газарт Онцгой байдлын газрын харъяа Гал түймэр унтраах Аврах 40 дүгээр ангитай хамтран байнгын хяналтын цэгийг ажиллуулж, хөдөөгийн малчин өрхүүдэд сэрэмжлүүлэг хуудас тараах ажлыг зохион байгуулж ажилласан. Давхардсан тоогоор нийт 283 өрхөд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг хуудас өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

Сум хөгжүүлэх сангаас 11 иргэнд 140,0 сая төгрөгийн зээл олгож СХС-ийн программд зээлдэгчийн мэдээллийг бүрэн орууллаа.

Энэ сард ЛМ-программд шинээр газар өмчлөхөөр 32 иргэний өргөдөл, газар хашаа байшин худалдан авахаар 6 иргэн, шинээр эзэмшихээр 18 иргэн 4 аж ахуйн нэгжийн нийт 60 өргөдлийг хүлээн авч 14 иргэнд 1,4 га төмс хүнсний ногооны газрыг, 1 аж ахуйн нэгжид 5 га газрыг тус тус эзэмшүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Газрын шинэчилсэн хаягжуулалтын ажлын хүрээнд сумын хэмжээнд 2040 нэгж талбарын хаягжуулалтыг ЛМ болон Arcgis программд тулгалт хийж шинэчилж дуусгасан. Мөн энэ сард 5 иргэн, 2 ААН, 10 төрийн байгууллага-д газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж гэрээ байгуулсан. газар эзэмших эрхийн гэрчилгээг 3 иргэн чөлөөлүүлж 4 иргэн, 3 аж ахуйн нэгж барьцаанд бүртгүүлсэн.

2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар улаанбуудайн тариалалт 48,6 хувь буюу 4238 га, төмсний тариалалт 86,1 хувь буюу 72 га, хүнсний ногооны тариалалт 60 хувь буюу 48 га-д тариалалт хийгдээд байна. Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас 1,5 тн үрийн төмс болон лууван, хүрэн манжин, шар манжингийн үр ирснийг ногоочдод тараан олгосон.

БСШУС-ын сайдын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Заавар батлах тухай” А/220 тоот тушаалын дагуу ЕБС-ийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд ЭЕШ-д бэлтгэх давтлагыг зохион байгуулж байгаатай холбогдуулан бэлтгэл ажлыг хийж, сумын онцгой комиссоос автомакс болон халуун хэмжигчийг хүлээлгэн өглөө.

“Ажлын байран дахь хүчирхийлэл дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх” уриан дор зохион байгуулагдаж байгаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сарын аяныг байгууллагадаа амжилттай зохион байгуулж ажиллалаа. Албан хаагчидтайгаа хамтран “Ажлын байран дахь хүчирхийлэл дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх” уриан дор “Байгууллага дахь хүний эрх, ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтаас сэргийлэх”, “Ажлын байрны соёл”, “Ажлын байрны эмх цэгц-5 С зарчим”, “Ажлын байранд зөв суух” сэдэвт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.

Сумын эрүүл мэндийн төвд тайлант сард хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 24, алсын дуудлага 18, ойрын дуудлага 67, яаралтай тусламж үзүүлсэн хүний тоо 21, осол гэмтэл 6, урьдчилан сэргийлэх үзлэг 184, амбулаторийн үзлэг 476, гэрийн эргэлтээр тусламж үзүүлсэн иргэн 274 байна. Сумын 3428 иргэнд “Коронавирус өвчнөөс сэргийлье” сэдэвт сургалт зохион байгуулсан. Төрийн болон төрийн бус байгууллагын 19 аж ахуйн нэгжийн нийт 4849 м² талбайд халдваргүйтгэл хийсэн.

Ерөө сум:

Хаврын тариалалтын ажил эхэлсэнтэй холбогдуулж 1,2-р багийн мал хариулгыг 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлүүлсэн. Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Гянт болд” нөхөрлөл, Ногоондов, Дарь-Эх хэсгийн мал бүхий

иргэдийн санаачлага, оролцоо дэмжлэгтэйгээр малын тарилгын хашааг шинээр барьж, мал тарилгын ажлыг гүйцэтгэж, 60-аад өрхийг хамруулсан.

Сумын хэмжээнд улаан буудай тариалалт, төмс, хүнсний ногоо тариалтын ажлын хэсгийг байгуулсан. 5 дугаар сарын 25-ны байдлаар 13100 га-д улаан буудай, 64 га-д арвай, 130 га-д рапс, 79 га-д төмс, 15,8 га-д лууван, 9 га-д сонгино, 3,9 га-д хүрэн манжин, 1,2 га-д сармис тус тус тариалсан мэдээтэй байна.

Буурагчин 2-р багийн Өлөнт нэртэй газар уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй “Монлид трейд” ХХКомпани нь COVID-19 цар тахал өвчинтэй холбогдуулан эдийн засаг хүндрэлтэй байгаа энэ цаг үед сумын иргэдэд 145 шуудай төмсийг, 100 кг Голландын Стурон сортын төл сонгины үрийн хамт буцалтгүйгээр тусламж болгон олгосныг 144 өрхөд дэмжлэг болгон хүргэж ажиллалаа.

2020 оны 05 дугаар сарын 15-нд А/136 тоот захирамжийн дагуу 9 дэлгүүрийн архи, согтууруулах ундааны хоригийг тавьж, өглөөний 10:00 цагаас оройн 20:00 цагийн хооронд худалдан борлуулах тухай захирамжийг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж ажиллалаа.

Авто тээврийн хяналтын улсын үзлэг Ерөө суманд 2020 оны 05 дугаар сарын 9,10-ны өдрүүдэд, Бугант тосгонд 2020 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Авто тээврийн улсын үзлэгээр онцгой комиссын гишүүд ээлжээр жижүүрлэн үзлэгт автомашинаа хамруулж буй иргэдийн гарыг ариутган, маск зүүх шаардлагыг тавьж ажиллалаа.

2020 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Самбартай хөтөлөөс Бугант тосгон хүртэлх 18 км замыг Сэлэнгэ Азза ХХК-тай хамтран засварлаж байна. Бугант тосгоны Ди зэт энд Ай ХХК, Капитал авто сервис ХХК, ЭБНЗ ХХК, Бугант нандин ХХК, иргэн Лхагвадорж нар дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

Сумын 1,2 багийн малчдын болон ээлжийн бүлгийн хүүхдүүдэд зориулан бүлгийн багш нар хичээлийн 6 чиглэлийн хүрээнд 60 ширхэг ном хэвлэн бэлтгэж 2020.04.27-ны өдөр сумын 1-р багийн нутаг дэвсгэр Энхтал, Хужирт, Хандгайт хэмээх газрын малчдын хүүхдүүдэд хүргэж өгч эргэх холбоотой ажиллалаа.

БСШУСЯ-ны хэвлэн гаргасан “Цэцэрлэгт хамрагдаж чадаагүй хүүхдүүдэд зориулсан гарын авлага”-ыг малчдын 14, бэлтгэл бүлгийн 70 хүүхдүүд нийт 84 ширхэг гарын авлагыг бүлгийн багш нар эцэг эх асран хамгаалагчдад хүлээлгэн өгөв.

БСШУС-ын сайдын 2020 оны 05 дугаар сарын 07-ны А/220 "Заавар батлах тухай" тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 05 дугаарсарын 11-ний өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Дээрх тушаалын дагуу багш, ажилчид, сургуулийн удирдлагууд давтлага хийх анги танхим, сургуулийн орчинд ариутгал халдваргүйтгэлийг хийж орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. 12а ангийн эцэг эхчүүдтэй хамтран “Багшийн туслах 800” аппликейшнийг хүүхэд бүрийн гар утсанд суулган ажиллаж байна. Тус аппликейшн нь сарын 30000 төгрөгийн хураамжтай бөгөөд эцэг эхчүүдээс 210000 төгрөг, сургуулийн захиргаанаас 150000 төгрөг гаргаж сурагчдын утсанд суулгаснаар хүүхэд бүр хичээлүүдээ онлайнгаар үзэх, цахим сорилгод оролцох боломжтой боллоо.

Сумын ЭМТ-д 05 дугаар сард амбулаториор нийт 293 иргэнийг үзлэгт хамруулан Стационарт 26 хүнийг хэвтүүлэн 365.0 мян/төгрөгийн эм тариа, ороох боох материал зарцуулсан. Түргэн тусламжийн нийт 111 дуудлага хүлээн авснаас, алсын 12 дуудлагад явж үйлчилсэн.

2020 оны 05-р сарын 9-ны өдөр Ялалтын баярт зориулан Соёлын төвөөс Ерөө суманд ажиллаж амьдарч байсан ахмад дайчдын түүхийг хойч ирээдүй залуусдаа сурталчлах зорилгоор танилцуулга бэлтгэн цацлаа.

Өнгөрсөн онд ойн дагалт баялаг, самар, жимсний ургац муу идэш тэжээлийн хомсдлын улмаас суурьшлын бүс рүү баавгай орж хүн, мал руу халдах тохиолдлууд гарсан ба намар тарга тэвээр муу авч намар орой ичсэн тул “Зэрлэг амьтны халдлагаас” иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах болзошгүй аюулаас

урьдчилан сэргийлэх зорилгоор малын хариулгад бага насны хүүхдийг явуулахгүй байх, эцэг эхчүүд хүүхдээ ганцааранг хараа хяналтгүйгээр гэрт нь үлдээж мал эрэн хайхгүй байх, машин мотоциклоо асахад бэлэн байлгах зэрэг зөвлөмж, гарын авлага бэлтгэн алслагдсан айл өрх, малчдад, үр тарианы аж ахуй нэгж, ногоочид, зөгийн аж ахуй эрхэлдэг иргэдэд сэрэмжлүүлэг өгч ажиллалаа.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын гүйцэтгэл явцтай танилцан малчдын санал хүсэлт сонсож малчдад мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга хийснээр ямар ач холбогдолтой болох талаар зөвлөгөө өгч ажилласан байна. Зүүн, баруун сэнстэй, Хужирт, Чулуутын нийт 8598 үхэрт Боом, Дуут хавдраас урьдчилан сэргийлэх вакцин хийлээ. Мөн Бугант тосгоны “Бадаанзүрх” МЭҮНэгжийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц гүйцэтгэлтэй танилцан малчидтай уулзаж мал эмнэлгийн хуулийн зөвлөгөө, урьдчилан сэргийлэлт хийхийн ач холбогдлын тухай мэдээлэл зөвлөгөөн хийж Ходоод, Дөхөм, Баянголын 2432 үхэрт Боом, Дуут хавдраас урьдчилан сэргийлэх вакцин, 1645 хонинд Боомоос урьдчилан сэргийлэх вакциныг хийж гүйцэтгэлээ.

Зүүнбүрэн сүм:

2019-2020 оны хичээлийн жилд 12 дугаар ангийг 34 суралцагч төгсөх бөгөөд 30 суралцагч ЭЕШ өгөхөөр бүртгүүлсэн. БСШУС-ын сайдын А/220 тоот тушаалын хэрэгжилтийг ханган 6 ангийг давтлага хичээллүүлэхээр бэлтгэж, өглөө бүр сургуулийн эмч 07:30–08:00 цагийн хооронд сурагчдын биеийн халууныг үзэж, амны хаалт, бээлий зэрэгт хяналт тавин тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Мэргэжлийн багш бүр хичээлийн онцлогоос шалтгаалан телевиз болон проектор ашиглан давтлагыг хийж байна.

Монгол хэлний хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 16 суралцагчийг 2 бүлэг, англи хэлээр өгөх 17 суралцагчийг 2 бүлэг, математикаар өгөх 22 суралцагчийг 2 бүлэг, нийгэм судлалаар өгөх 28 суралцагчийг 3 бүлэг, хими-биологоор өгөх 4 суралцагч, физикээр өгөх 12 суралцагчийг 1 бүлэг болгон хувааж өглөө, өдөр 2 ээлжинд 3, 3 цагаар давтлага зохион байгуулж ангийн ариун цэврийн буланд ариутгалын бодис, гар ариутгагчийг байрлууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчид хувиарийн дагуу хариуцлагатай эргүүл жижүүрээр ажиллаж “Идэр” дэлгүүрийн орчин, тоглоомын талбайгаар ажиллаж, иргэдэд урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг өдөрт дунджаар 30-40 ширхгийг олгож байна.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төв 4 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн. Амбулатороор 300 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 105, урьдчилан сэргийлэх үзлэгээр 110, диспансерийн хяналтаар 59, гэрийн идэвхтэй эргэлтээр 12, дуудлагаар 14 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлээ.

Сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын А/100 тоот захирамжаар хаврын тариалалтын хугацааг тогтоож аж ахуй нэгж, иргэдэд сурталчлан ажиллалаа. Сумын хэмжээнд тариалалтын явц өнөөдрийн байдлаар улаан буудай 6937 га, 70 га төмс, 180,7 га талбайд хүнсний ногоо, 30 тэжээлийн ургамал, 200 га рапс тариалж улаан буудайн тариалалт 72,8 хувьтай, төмс, 194 хувьтай, хүнсний ногоо 132 хувьтай явагдаж байна. Тариалалт дууссан аж ахуйн нэгжийн талбайг талбай тус бүрээр хүлээн авч байна.

Сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/103 тоот захирамжаар “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах”- ажлын хэсгийг байгуулав.

МЭҮН-д төл малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2700 толгой төл, 300 амьтанг тус тус хамруулж, дархлаажуулалт 40 хувьтай явагдаж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан, Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу шуурхай бэлэн байдлыг хангаж, “Энх бүрэн сүрэг”, “Оюут сүрэг” МЭҮН-д хлорын шохой 200 кг, байммекон 8 кг, hi-cop 14 кг нөөцийг бүрдүүллээ.

Сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/70 тоот захирамжийн дагуу, малын сэг зэм, орчны ариутгал халдваргүйжүүлэлтийг зохион байгуулж, орчны ариутгал халдваргүйтэлд 500 м2 талбай, худалдаа үйлчилгээний агуулах, байр, зоорийг халдваргүйжүүлж 1,976,9 м2 талбайг тус тус хамрууллаа.

МЭҮН-н мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сумын нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, төхөөрөх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгон 1880 кг мал, амьтны мах, 235 толгой малын гэрчилгээг хянаж, нэгдсэн мэдээллийн сантай холбогдон баталгаажуулж ажиллалаа.

Аймгийн БОАЖ-ын газраас “Хандлагаа өөрчилъе” уриан дор хэрэгжүүлсэн өрх бүр хашаандаа 2 ширхэг мод тарих зөвлөмж, уриалга, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэх, сурталчлах ажлыг зохион байгууллаа. 2 аж ахуйн нэгж, байгууллага, 16 иргэн 458 ширхэг жимс жимсгэнэ, 300 ширхэг гоёлын мод, 6 ширхэг улиас мод тариалж, ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.

“Зөв дадал – Ногоон ирээдүй” аяны хүрээнд бүх нийтээр мод тарих өдрийг угтаж мод тарих хялбаршуулсан гарын авлагыг бэлтгэн өрхүүдэд тараалаа.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, сумын Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 14-ны өдөр баталсан “Хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулах тухай” А/21 тоот захирамжаар баталсан хуваарийн дагуу сумын Онцгой комисс, Мэргэжлийн ангийн гишүүд, ЗДТГ-ын албан хаагчид эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар батлагдсан “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байгууллагууд мод цэцэг тарьсан. Сумын нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, байгаль орчноо хамгаалах үйлсэд хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 3 байгууллага 40 ширхэг мод, харъяалалтай газруудад цэцэг тарьж, 13 иргэн 8 төрлийн 122 ширхэг жимсний мод тариалсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны А\133, Сумын Засаг даргын А\85 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж Аймгийн мал үржлийн нэгжийн дарга Э.Мягмарсүрэн, ХАА-н тасгийн мэргэжилтэн Х.Дуламсүрэн нар 2020 он 05 сарын 08-10-ний өдөр Говь-алтай, Баяд, Хангай үүлдрийн хонь, Алтай улаан үүлдрийн ямааны 10 суурийн 3000 малд үзлэг ангилалт явуулж, ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн. Мөн үзлэг ангилалтын явцад малчдад зржлийн өсвөр хээлтүүлэгч хэрхэн бэлтгэх, чанарыг хэрхэн хадгалах хамгаалах сайжруулах талаар зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Тус суманд “Адра” Олон Улсын байгууллагын Органик хөдөө аж ахуй төслийн зөвлөх багш Алтангавъяа нийт 20 иргэнд 2 ээлжээр “Хоршооны засаглал, менежмент”-ийн сургалтыг зохион байгуулж “Бумбат таван богд” хоршооны гишүүд хамрагдсан. Мөн аймгийн ХХААГ, “Хөгжлийн шийдэл” ТББ-аас “Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн зээлийн танилцуулга” сургалтанд иргэн аж ахуйн нэгж хоршооны 10 төлөөлөл хамрагдсан.

Сумын хэмжээнд хаврын тариалалтын явц 5-р сарын 20-ны өдрийн байдлаар улаан буудай 2600 га-д, төмс 37 га-д, хүнсний ногоо 128 га-д 16 аж ахуй нэгж, 72 иргэн тариалт хийгээд байна.

Дотрын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж 5 өрхийн 2690 толгой мал, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 44 өрхийн 8666 үхрийг боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан.

Тус суманд Улсын хөрөнгө оруулалтаар ахмадын байрны тоног төхөөрөмж, их засварын ажил 10,0 сая төгрөгөөр хийгдэж, соёлын төвийн барилгын их засварын тендерийн ажил явагдаж байна. Мөн аймгийн замын сангийн хөрөнгө

оруулалтаар зам засвар тэмдэг тэмдэглэгээ хийх 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил 100 хувь хийгдээд байна.

Тайлант сард сумын Эрүүл мэндийн төвөөс амбулаторийн үзлэг 34, урьдчилан сэргийлэх үзлэг 95, идэвхитэй хяналтаар 39, хүлээн авахаар үйлчлүүлсэн 68 хүн үйлчлүүлсэн. Хэвтэн эмчлүүлэх хэсэгт шинээр 9 хүнийг хэвтүүлэн эмчилж, өвчнийтүүхийг нээж, эмчийн заавраар эмчилгээ асаргаа сувилгаа хийгдэн, 8 хүнийг эмнэлгээс гаргаж картанд тэмдэглэл хөтөлж зөвлөгөө өгч ажиллаж байна. Хөдөлмөрийн чадвар алдалт сунгуулах хуралд 6 иргэнийг картыг эмч нар авч явж сунгалтыг хийлгэсэн.

Сумын төвийн 0-59 насны 40 хүүхдэд гэрийн эргэлт хийж эцэг эх асран хамгаалагч нарт зөвлөгөө өгч ажиллалаа.

Эмчилгээний нөөцөд 2450200 төгрөг, гадуур эмийн санд 2583220 төгрөгийн эм тариа ороох боох материалыг татан авч эм тарианы нөөцийг бүрдүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулахтай холбогдуулан ариутгал үйлчилгээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Сургууль орчмын бүсэд цэвэрлэгээ, ариутгалыг хуваарийн дагуу тогтмол хийж, гадны хүн нэвтрэх, хүн олноор цугларахгүй байх арга хэмжээ авсан.

ЕБС-ийн номын сангаас Жавхлант цахим номын сантай хамтран Дэлхийн номын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд хүүхэд багачуудын авьяасыг нээн тодруулах, эх хэлээрээ зөв цэгцтэй ярих чадварыг хөгжүүлэхэд зорилгоор “Үлгэрч багачууд-2020”, “Уран жиргээ- 2020” уралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж оролцсон сурагчдын бүтээлийг Жавхлант цахим номын сан Face book группт байршуулж иргэд олон нийтэд түгээж сурагчдын авьяас чадварыг олонд түгээж ажиллалаа. Тус уралдаанд Б.Уянга багштай 9а ангийн сурагч Д.Бумадарь, Б.Эрдэнэтуяа багштай 3а ангийн сурагч Э.Саранзаяа нар бусдыгаа манлайлан амжилттай оролцлоо.

Өдөр бүр багш нар өглөө 08:00 орой 18:00 цаг хүртэл хариуцлагатай жижүүрээр ажиллаж байгаа бөгөөд багш, суралцагч, албан хаагчдыг амны хаалттай нэвтрүүлж, тэдний биеийн халууныг тогтмол хэмжин, тэмдэглэл хөтөлж, шаардлагатай тохиолдолд эмчийн үзлэгт хамруулах заавраар ажиллаж байгаа ба сургуулийн удирдлагын баг хяналтын жижүүрийн үүргийг давхар гүйцэтгэж байна.

Хөл хорио тогтоосонтой холбогдуулан сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан теле хичээлийн шинэчилсэн хуваарийн дагуу бүлгийн багш нар өдөр бүр эцэг эхчүүдтэй утас болон цахимаар холбогдон ахуйн ослоос сэргийлэх сэрэмжлүүлэг зэрэг зөвлөгөө зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байгаагаас гадна гэрээр айлчлан телехичээлийн гэрийн даалгаврыг шалгах ажлыг зохион байгуулсан. Дэлхийн хэмжээнд тархаад байгаа Covid-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн хөл хорио тогтоосонтой холбогдуулан сургуулийн Өмнөх насны хүүхдүүдэд зориулсан теле хичээлийн шинэчилсэн хуваарийн дагуу бүлгийн багш нар өдөр бүр эцэг эхчүүдтэй утас болон цахимаар холбогдон ахуйн ослоос сэргийлэх сэрэмжлүүлэг зэрэг зөвлөгөө зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байгаагаас гадна гэрээр айлчлан телехичээлийн гэрийн даалгаврыг шалгах ажлыг зохион байгуулан ажиллаж, сумын сургуульд орох насны 37 хүүхдэд гарын авлага, эцэг эхчүүдэд зөвлөмж тарааж тайланг БСУГазарт мейлээр хүргэн ажилласан.

Туслах багш нар болон жижүүрүүд бүлгийн өрөө тасалгаа болон дотор гадна талд их цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт, ариутгалыг хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэж байна

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан цахим “Удмаа мэдэж угийн бичгээ хөтөлцгөөе” уралдаанд Моностой 2-р багийн ахмад настан А.Хөдөлмөр өөрийн “Угийн шаштир”, “Удмын зураглал”-аараа ахмад насны төрөлд дэд байр эзэлсэн.

Шаамар сум:

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хорио цээрийн дэглэмийг сунгасны дагуу сумын “Шуурхай штаб”-ын хариуцлагатай жижүүрийн хуваарийг сунгаж, 2020 оны 05 дугаар сарын 30-ныг хүртэл сунган олон нийтийн газар бага насны хүүхүүдийг зорчуулахгүй байхад хяналт тавих, албан байгууллага аж ахуй нэгжүүдэд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийхэд хяналт тавих өдрийн цагаар ажиллах олон нийтийн эргүүлийг сумын Засаг даргын 2020 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн А/39 дүгээр захирамжаар байгуулсан, ажлын хуваарийг сунган байгууллагын албан хаагчдыг дахин ажиллууллаа.

Сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг хүнсний дэлгүүрүүдэд байгаа архи согтууруулах ундааг тоолж лацдах ажлын хэсгийг томилон, 9 дэлгүүрээс тусдаа агуулахтай “Шонхлой”, “Сод Монгол групп” ХХК-ий архины агуулахыг хэсгийг төлөөлөгчийн лацаар бусад агуулахгүй 7 дэлгүүрийн архи 747 ширхэг, вино 33 ширхэг, пиво 700 ширхэгийг тоолж хайрцаглан лацдаж, тэмдэглэлийг үйлдэн баталгаажуулж ажилласан.

Суманд, ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаа явуулж буй “Үржин бадрах” ХХК аж ахуй нэгж байгууллагуудын бие засах газар, айл өрхийн нүхэн жорлонг шингэн болон хуурай ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

Сум, тосгоны Эрүүл мэндийн төвөөс иргэдэд Шинэ коронавирусын халдварын урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг, гарын авлагыг бэлтгэн хүргүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, халдварт өвчний талаарх мэдээллийн холбогдох дээд байгууллага Эрүүл мэндийн яам, аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаас татан авч сумын болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж иргэдийг мэдээллээр хангаж байна. Үүнд: 2020 оны 04 дугаар сарын 24-ны байдлаар өвчлөлт, тархалтын талаар 46 удаа, амны хаалт хэрэглэх зөвлөмж 45 удаа, сэрэмжлүүлэг 36 удаа, зөвлөмж 82 удаа, цахим зөвлөмж, 43 гаруй видео бичлэг, шторкыг байршуулж, 9658 иргэн хандалт хийж хуваалцсан байна.

Сумын Эрүүл мэндийн төвийн байгууллагаар тайлант хугацаанд амбулаторын үзлэгээр 146 иргэн үзүүлж, томуугийн өвчлөлтэй 0-5 насны 2 хүүхэд бүртгэгдэж, стационарын үзлэгээр 7 иргэд үзүүлснээс амьсгалын замын эмгэгийн улмаас хэвтэн эмчлүүлсэн өвчтөн байхгүй ба 7 хүн хэвтэн эмчлүүлснээс эдгэрч биеийн байдал сайжирсан энд архаг хууч өвчтэй хүмүүс хэвтэн эмчлүүлж байна. 2020 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар нийт 43 дуудлага хүлээн авснаас томуу, томуу төст өвчний дуудлага байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумын сонгуулийн хороог аймгийн сонгуулийн хорооноос байгуулж, 5 хүний бүрэлдэхүүнтэй байнгын бус ажиллагаатай сумын сонгуулийн хороо 2020 оны 04 дүгээр сарын 22-ноос үйл ажиллагаагаа тогтмолжуулан Сонгуулийн тухай хууль тогтоомж, мэдээ мэдээллийг иргэдэд сүрталчан таниулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Сумын хэсгийн хороонд ажиллах төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын судалгааг гарган цахим сургалтанд хамруулж, сорилыг амжилттай өгснөөр сумын хэсгийн хороонд ажиллах төрийн байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүн хэсэг тус бүрт 9 гишүүн ажиллахаар байгуулагдсан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор батлагдсан сумын Дэлгэрхааны 1-р багийн дэнжийн “Гүний худгийн тохижилт, ухаалаг тоолууртай болгох ажил”-ыг 25.0 сая төгрөгөөр гүйцэтгэх, Дулаанхаан тосгонд “Хүүхдийн тоглоомын талбайн ажил”-ыг 35.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр баатлагдаж, сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж, аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн хянуулж, сумын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/459 дугаарын захирамжаар эрх шилжүүлсэн “Сумын Охиндий 2-р багийн замын засвар, зам талбай хийх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 16-ны А/31 тоот захирамжаар 5 хүний

бүрэлдэхүүнтэй байгуулж, сумын Засаг дарга үнэлгээний хорооны гишүүдтэй 2 удаа уулзаж санал бодлоо солилцон 5-р сард багтаан дуусгаж ажиллахыг үүрэг болгосон. Үнэлгээний хорооны гишүүд 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр tender.mn цахим сонгон шалгаруулалтыг зарласан хэдий ч 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр нээхэд нэг ч ААН оролцоогүй тул Сэлэнгэ аймгийн “АЗЗА” зам арчлалтын байгууллага, “Сэлэнгэ Есөн эрдэнэ” ХХК, Дархан аймгийн “АЗЗА” замын компанид урилгыг сумын Засаг даргын орлогчоор албан тоот хүргүүлсэн хэдий ч 2020 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн цахим сонгон шалгаруулалтад дахин нэг ч аж ахуй нэгж оролцоогүй байна. Энэ талаар зам арчлалтын мэргэжлийн байгууллагад хандахад төсөвт өртөг бага, холоос техник тоног төхөөрөмжөө татахад ихээхэн зардал гарах тул оролцоогүй болохыг мэдэгдсэн. Мөн сумын Дэлгэрхааны 1-р багийн дэнжийн “Гүний худгийн тохижилт, ухаалаг тоолууртай болгох ажил”-ыг 25.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх ажлыг сонгон шалгаруулалтыг цахимаар 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зарлаж, 2020 оны 05 дүгээр сарын 22-ны өдөр нээхэд мөн оролцогч саналаа ирүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолоор орон нутагт үйл ажиллагаа явуулж буй "Нэг цонхны үйлчилгээ"-г өөрчилж, операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг "Үйлчилгээний ээгдсэн төв" байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж эхэллээ.

Малын тоо толгой жил бүр өсөж бэлчээрийн даац багтаамж хүрэлцээ муутайгаас бэлчээр талхлагдаж доройтож байгаа суварга, Сүхбаатар самбар, ээж модны орчмын 400 га талбайд мэрэгчидтэй тэмцэх оготно устгалыг ажлыг Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, ХХҮГ-газартай хамтран зохион байгуулж, байгаль орчинд нөлөөгүй энгийн, механик, биологийн аргаар устгалыг хийж нүхийг шороогоор булж хөрсний эвдрэлийг хэвийн байдалд оруулан ажиллалаа. Оготно устгалын ажилд орон нутгаас 2 ачааны машин бусад багаж хэрэгслээр ханган 7 хоногийн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 10 иргэнийг түр ажлын байраар ханган цалин хөлсийг аймгийн ХХҮГ-аас санхүүжүүллээ.

Монгол Улсын Хүнс, хөдөө, аж, ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 04 сарын 09 өдрийн 01/1342 тоот бичгийн дагуу ямааны ноолуурийн урамшуулалд хамрагдах сумын ямаатай малчин мал бүхий иргэдийн ямааны тоо толгойг нэг бүрчлэн гаргаж дансны дугаар, ямааны тоог нягтлан шалгаж хүргүүллээ. Үүнд: Дэлгэрхаан багт 43 малчин, мал бүхий өрхийн 3464 толгой ямаа, Охиндий багт 51 малчин, мал бүхий өрхийн 2595 толгой ямаа, Дулаанхаан багт 17 малчин, мал бүхий өрхийн 1114 толгой ямаа, нийт 111 малчин, мал бүхий өрхийн 7173 толгой ямаатай өрхийн судалгааг гарган аймгийн ХХААГ-ын МАА-н албанд хугацаанд нь хүргүүлэв.

Монгол Улсын Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/133 тоот захирамжийн дагуу сумын ажлын хэсэг гарган Дэлгэрхааны 1-р баг, Охиндий 2-р багийн хонь, ямаатай 9 малчин өрхөд бог малын ангилалтыг 376 толгой хонь, 185 толгой ямаанд хийж нийт 561 бог малыг ангилалтад хамрууллаа.

Сум хөгжүүлэх сангийн 2020 оны 04 дүгээр сарын эргэн төлөлтийн мэдээг аймгийн ХХААГ-т 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүргүүлэн, сум хөгжүүлэх сангийн нэгдсэн програмд 04 дүгээр сарын эргэн төлөлтийн мэдээг шивж баталгаажууллаа.

Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг олгох, хяналт тавих ажлыг орон нутагт зохион байгуулж, орон нутгийн иргэдээс жимс жимсгэний модны 15 гаруй нэр төрлийн 1376 ширхэг суулгацыг УБ хотын чиглэлд тээвэрлэх 4 иргэн, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын чиглэлд 2 тн гурвалжин будааны үрийн нөөцийн тээвэрлэлт хийсэн 1 аж ахуй нэгжийн тээврийн хэрэгсэлд гарал үүслийн гэрчилгээ тус тус олгон хяналт тавьж ажиллалаа.

2020 оны төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх мөн сумын ногоочдын хүсэлтийг харгалзан Мандал сумын “Эдэн хараа” ХХК-тай тохиролцон

эргэн төлөх хөнгөлөлттэй нөхцлөөр 100 иргэнд төмсний үр, 200 иргэнд сонгины үр нийт 250 кг төл сонгино, 4 тонн төмсний үрийг зохих журмын дагуу тус тус гэрээ хийж ногоочидод хувиарлан ажиллалаа. Аймгийн ХХАА-н газраас сумын ногоочдод дэмжлэг үзүүлэхээр хувиарлан ирүүлсэн хүрэн манжин, шар манжин, лууван, төмсний үрийг хүнсний ногооны үрний хэрэгцээ нэн шаардлагатай байгаа ногоочидод хувиарлан бүртгэлжүүлэлт хийж давхардсан тоогоор төмсний үр 38 иргэнд, хүрэн манжингийн үр 73 иргэнд, шар манжингийн үр 58 иргэнд, луувангийн үр 67 иргэнд олгосон.

“АДРА” олон Улсын байгууллагын органик түншлэл төсөл 2018 оноос орон нутагт амжилттай хэрэгжиж суманд бүл, хоршооллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Бүтээлч Шаамар”, “Органик бал хоршоо”-д хамрагдан санхүүгийн зохих дэмжлэгийг авч, бизнесийн чадавхиа дээшлүүлэх сургалт, зөвлөгөөнд тогтмол хамрагдан ажиллаж ирсэн. Уг байгууллагаас 05-р сарын 21-ний өдөр зохион байгуулсан “Хамтын баталгаажуулалтын сургалт, тангараг өргөх арга хэмжээ”-ний үеэр 12 гишүүн тангараг өргөж, тус 2 хоршоо нь хамтын баталгаажуулалтын байгууллага болохоо батлан, хамтран ажиллах гэрээгээ байгуулж, энэ чиглэлээр зохион явуулсан сургалтанд 2 хоршооны 19 гишүүнийг хамруулж, чадвхижууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын хүрээнд сумын нутаг дэвсгэрт үхэж хорогдсон малын хүүр, сэг зэмийг устгах ажлыг Мал эмнэлгийн үржлийн нэгж, багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Охиндий 2 дугаар багийн нутаг модон дотор явуулын хүмүүсийн хаясан байсан 15 ширхэг хонины арьс, мөн голын гарам эрэг дагуух малын сэг зэмийг хогийн цэгт тээвэрлэн хүргэж, ухсан нүхэнд шатааж устгал хийсэн.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/10 тоот “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу сумын Засаг даргад танилцуулж, захирамж батлуулан багийн МЭҮН-дэд хувиалан хүргүүлж, мал эмнэлгийн арга хэмжээг эхлүүлэн, нэгдсэн системд төлөвлөгөөг бүртгэн оруулсан. Мал эмнэлгийн нэгдсэн системд МЭҮН-ийн 2019 оны мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн судалгаа, 2020 оны мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын үзлэгийн арга хэмжээнд хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын ажлыг фото зургаар баталгаажуулан мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэн баталгаажуулсан.

Сумын багийн Мал эмнэлэг, үржлийн нэгжийн эмч нарт нэгдсэн системд ажиллахад анхаарах асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч бүтээгдэхүүний мэдээг нэгтгэн холбогдох дээд газрын ахлах байцаагчийн “mail” хаягаар илгээсэн. Бүртгэлээр үржилд-8 адуу, 4 үхэр, хүнсэнд 11 үхэр, үйлдвэрлэл худалдаанд 1 адуу гарал үүслийн зөвшөөрөлд хянаж, баталгаажуулсан байна.

Сумын ЗДТГ-ын албан хаагчидтай хамтран Сүхбаатар өндөрлөг орчимд Хандлагаа өөрчилье, Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ байршуулан ажиллалаа. Сумаас түр ажлын байраар хангагдсан 10 иргэнтэй хамтран төв хогийн цэг, Эрүүл мэндийн төвийн орчмын нийтийн эзэмшлийн талбайн хогийг цэвэрлүүлж 10 портер хогийг төв хогийг цэгт тээвэрлэн хаялаа. Мөн хог хаягдлын талаар болон ой хээрийн түймрийн талаарх зурагт хуудас, санамж, гарын авлагыг 160 гаруй иргэнд танилцуулж, тараан бүртгэж гарын үсэг зуруулж баталгаажуулж ажилласан.

“Зөв дадал ногоон ирээдүй” сарын аяны хүрээнд “Хэрэглээгээ зөв болгоё”, “Зөв дадал ногоон ирээдүй”, “Таны дуу хоолой байгалийг хамгаална”, “Байгалиа хамгаалъя”, “Өрх бүр хашаандаа хоёр мод таръя”, “Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ”, “Хөрсөө хойч үедээ хэвээр үлдээ” зэрэг цахим контентүүдийг татан авч сумын төрийн захиргааны болон төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд зурагт хуудас, гарын авлага тараан сумын “Шаамар сум ЗДТГ” фэйсбүүк хуудас, shaamar@selenge.gov.mn цахим хуудаст уг контентийг байршуулж, нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. Мөн “Ногоон паспорт-ногоон төгөл аян”-ны хүрээнд сумын айл, өрхүүдийг хашаандаа мод тарья уриалыг

фэйсбүүк, цахим хаягаар мэдээлж, төрийн албан хаагчид, иргэдийг уг уриалгад татан оролцуулж сурталчлан ажилласан.

Монголын Татварын албанаас жил бүрийн тав дугаар сарын хоёр дахь долоо хоногт “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ жилийн хувьд улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үе таарч байгаа учраа 21 дэх удаагийн “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг “Эрсдлийн эсрэг хамдаа” уриан дор энэ сарын 4-8-ны өдрүүдэд цахим орчинд тэмдэглэн өнгөрүүлээ.

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймаг дахь төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс ирүүлсэн төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зарим арга хэмжээний тухай, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай албан бичгүүдийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу Засаг даргын Тамгын газрын сул 4 ажлын байрны захиалгыг хүргүүлээд байна.

Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн ээлжит хуралдаанд сумын Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 2019 оны биелэлт, газар зохион байгуулалтын нэмэлт төлөвлөгөөг оруулж сумын Засаг даргын 2019 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт хангалттай үнэлэгдлээ.

Аймгаас зарласан “Иргэний хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд суманд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шинэ төрлийн Коронавирусээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний талаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. 2020 оны 05 дугаар сарын байдлаар сумын шуурхай штабын үйл ажиллагаа хэвийн явагдаж хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу ажиллан мэдээ тайланг Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн онцгой штабт хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Шуурхай штабын байранд хариуцлагатай жижүүр 1, хоол зөөх-3, ариутгалын 3, 1 дүгээр сургуулийн гал тогоонд -4 хүн ажиллаж шаардлагатай тохиолдолд бусад албан хаагчдын дуудан ажиллуулж байна. Б байр буюу халамжийн сувиллын түр тусгаарлах байранд 7 иргэн, 1 эмч, 1 сувилагч ажиллаж байна. Иргэдийн биеийн байдал хэвийн байна.

Мөн сургууль цэцэрлэгийн багш ажилчид 8 багийн нутаг дэвсгэрт эргүүл хийж бага насны хүүхэд гадуур явуулахгүй байх, маск зүүх талаар зөвлөмж өгч байна.

Цэцэрлэгт хамрагдах 5 настныг СӨБ-д бүрэн хамруулах, шинээр элсэн суралцах 6 настанг бүртгэн сургуулиудад хүргүүлэн хамран сургах тойргийн сургуулиудтай хамтран ажиллаж суурин хүн амын жилийн эцсийн статистик тоон үзүүлэлтийн дагуу хамран сургах тойрог бүрээр баг тус бүрээр гарган сургууль цэцэрлэгт хүргүүлсэн.

ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд захирамж гарган гэр бүлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх 8 баг тус бүрийн зорилтот өрхийн хүүхдүүдэд бэлэг өгөх ажлыг төсвийн дагуу зохион байгуулсан.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сүмээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 1000 ширхэг амны хаалт, 10 ширхэг гар ариутгагч, “Номтхан” өрхийн эрүүл мэндийн төвд 1000 ширхэг амны хаалт, 5 ширхэг гар ариутгагч хүлээлгэн өглөө. Мөн Баянханы 4 дүгээр багт 500 ширхэг амны хаалт хүлээлгэн өгсөн ба тус багийн зорилтод өрхийн 200 иргэнд тараалаа.

Хаврын тариалалттай холбоотойгор шуурхай штаб-ыг 9 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулж тариалалтын мэдээг ХХААГ-т өдөр тутам өгч байна. Сумын хүлэмж авах хүсэлтэй, төмс, хүнсний ногоо тариалдаг, жимс жимсгэний аж ахуй эрхэлдэг өрхийг хүлэмж үйлдвэрлэдэг байгуулгатай холбож хөнгөлттэй нөхцөлөөр 5 өрх хүлэмж авсан. ХХААГ-аас төмс, хүнсний ногооны 7 төрлийн үр олгосоныг сумын 8 багт тарааж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр” зарлах тухай 63 дугаар зарлигийн дагуу хаврын мод тарилтын өдрийг зохион байгуулж ажиллалаа. Энэ ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд орчин тойрон, болон хашаа хороо, цэцэрлэг, сад, цэцэрлэгт хүрээлэндээ цэвэрлэгээ, арчлалт, хамгаалалт цэнэг усалгаа хийж нэмж мод, бут, сөөг, цэцэг тарьсан байна. Мөн 8 багийн 545 өрх айл 23 аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн эзэмшлийн талбайд 1145ш мод, 2176 бут, сөөг тарьж нийт 895 иргэн албан хаагч нар оролцсон байна.

Сүхбаатар суманд улс, аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дараах ажлуудын тендер зарлагдаж, ажил эхэлсэн. Үүнд:

1. Ган замын 7-р баг Багш нарын байрны сантехникийн засвар-26.0
2. Сэлэнгэ тохижилт үйлчилгээний газарт ковш -150.0
3. 5-р сургуулийн цайны газрын дээвэр-40.0
4. 1-р цэцэрлэгийн дээвэр засвар-45.0
5. Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын фасад засвар-610.0
6. 3-60-н айлын дээвэр засвар-40.0
7. 1-р сургуулийн сантехникийн засвар-95.0
8. Сүхбаатар биет үсгэн хөшөө-35.0
9. Буурын голын тохижилт -20.0

Мөн 2021 онд хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын саналыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Мөн 2021 онд Орон нутгийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналуудыг багуудаас авч нэгтгэхээр ажлыг зохион байгуулаад байна .

2020 оны хагас жилийн малын түүвэр судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 19-н өдрийн А/109 тоот захирамжаар судалгааг явуулах ажлын хэсгийн захирамж гарч, цахим сургалтанд хамрагдсан. Хагас жилийн малын түүвэр судалгааг 5 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Орхон сум

Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид салбар чиглэл бүрээр мэдээ мэдээлэл өгөх, ажил мэргэжлээ сурталчлах ажлыг зохион байгуулахаар хуваарь батлуулан ажилласан бөгөөд 5-р сарын байдлаар 8 төрийн албан хаагч цахим орчинд 2019-2020 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ, төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хүргэж ажиллалаа.

Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн цахим орчинд Orkhon Sum Zdtg Selenge Facebook хаяг /3.7к дагагчтай/, Орхон сум ЗДТГ/1.7к дагагчтай/, Сэлэнгэ аймаг Орхон сум групп /3.2к дагагчтай/, Нарт Орхоны хүүхдүүд/2.2к дагагчтай/, SelengeorhonEmtбүртгэлтэй хаягуудаар мэдээлэл, сурталчилгаа, зөвлөмж, Улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрүүдийг хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

“COVID-19” халдвараас хамтдаа сэргийлье!!!, “Сумаараа маскаа зүүцгээе” аян, "Амны хаалтаа тогтмол зүүж хэвшин, өөрийгөө болон хайртай хүмүүсээ хамгаалъя" Challenge -үүдийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/130 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган 05-р сарын 30-ны өдрийг дуустал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаанд хориглосон талаарх мэдээллийг сумын төвийн архи согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрөлтэй 6 хүнсний дэлгүүрт мэдэгдэл хүргүүлэн хяналт тавин ажилласан.

Төр төсвийн байгууллагын ажилтан албан хаагчид маск оёх, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоотойгоор сайн дурын аяныг зохион байгуулан иргэдийг маскжуулах ажлыг зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2020 оны 05-р сарын 06-ны А/66 тоот захирамжийн дагуу “Оготно устгал”-ын нийтийг хамарсан ажлыг 05-р сарын 06-наас эхлэн 06-р сарын 12-ыг дуустал 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Тус нийтийг хамарсан ажилд 1,2-р багийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй, зорилтот бүлгийн 10 иргэнийг 5 мотоцикл

утагч төхөөрөмжтэй ажиллуулан түр ажлын байраар хангаж ХХҮГ-аас цалинжуулан ажилууллаа.

Сумын хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагууд ойр орчмын 50-100 м газрын хог хаягдал, тухайн байгууллагын хариуцсан ногоон байгууламж, Дархан-Эрдэнэтийн зам дагуух 9 км газар, нийтийн эзэмшлийн газрын ил задгай хог хаягдлыг цэвэрлэсэн. Тус ажлын хүрээнд нийт 75 төрийн албан хаагч оролцон 10 га газрын 6 тонн хог хаягдлыг цэвэрлэн сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт ачиж буулгасан байна.

Сумын хэмжээнд оны эхний нийт хээлтэгчийн 77,9 хувь төллөж гарсан төлийн 99,1 хувь бойжиж байна. Том малын хорогдол 0,11 хувьтай байна.

Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/110 тоот, сумын Засаг даргын 2020 оны А/69 тоот захирамжийн хүрээнд дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтанд сумын хэмжээнд мал амьтныг бүрэн хамруулах зорилгоор МЭТ, МЭҮН-д вакцин туулгалтын ажлыг зохион байгуулж эхлээд байна. Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэн тарилгыг “Бүрэн-Орхон” ХХК 5700 ишиг, “Эгдэм” БГБХН 8000 ишиг, нийт 13700 ишгийг 100 хувь хамруулсан. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг “Бүрэн-Орхон” ХХК 5523 үхэрт, “Эгдэм” БГБХН 4223 үхэр, нийт 9746 үхэрт хийж тарилгын явц 68 хувьтай явагдаж байна.

Хаврын тариалалтын ажил эхлэхтэй холбогдуулан аймгийн ХХААГ-аас сармис, төмс, шар манжин, лууван, хүрэн манжингийн үр ирснийг 2 багийн Засаг даргатай хамтран хашаандаа ногоо тарьдаг нийт 86 иргэнд хувиарлан өгч тариалалт хийлгүүлсэн.

Хаврын тариалалтын мэдээг өдөр бүр аймгийн ХХААГ-ын тариалалтын штабын жижүүрт өдөр бүр утсаар өгч байна. Улаан буудай 2830 га, төмс 135 га, хүнсний ногоо 148 га талбайд тус тус тариалалт хийгээд байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлэнд хамрагдах хүсэлт дараах чиглэлээр гаргасан: Өндөр ашиг шимт хээлтүүлэгч мал худалдан авах малчдыг дэмжих, сүү хөргөлтийн танк тоног төхөөрөмж худалдан авах гэсэн 2 чиглэлээр 4 иргэний материалыг хүлээн аваад байна.

Орхонтуул сум

Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж Ковид-19 халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Сумын төвийн ЗДТГ-ын дэргэдэх шуурхай штаб, Рашаант тосгоны Шуурхай штабуудад иргэдийг цаг үеийн мэдээллээр хангаж, сонор сэрэмжийг дээшлүүлэх үүднээс шуурхай штабын Хариуцлагатай жижүүрүүдийн хуваарийг шинэчлэн баталж, бусад байгууллагын хариуцлагатай жижүүрүүдийг удирдлага арга зүйгээр ханган, Мэргэжлийн хяналт болон Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавруудыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Ковид-19 халдварт өвчний үед бэлтгэл бэлэн байдлыг хангах үүднээс сумын төв болон Рашаант тосгоны Шуурхай штабуудтай хамтран гэр хороолол болон, Орон сууц хорооллуудаар тухайн өдрийн хариуцлагатай жижүүрүүд чанга яригчаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ болон Улсын онцгой комиссоос “Амны хаалтаа зүүцгээе” аяныг өрнүүлэн иргэдэд амны хаалтаа зүүж хэвших талаар шаадлага тавин ажиллаж байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Худалдаа үйлчилгээний байгууллагуудад Ковид-19 вирусын ариутгал халдваргүйтгэл, өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаас ирсэн зөвлөгөө мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөн хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагуудад “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн 2.23.4 заагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Одоогийн байдлаар ямар нэг зөрчил гаргасан аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдээгүй байна.

Сумын эрүүл мэндийн төвөөс тайлант сард нийт 752 үзлэг хийгдэснээс урьдчилан сэргийлэх үзлэг 85, амбулаторийн үзлэг 327, идэвхтэй хяналтаар 75, гэрийн эргэлт 148, дуудлага 92 үүнээс алсын дуудлага 7, гэрийн дуудлага 18 байна. Жирэмсний хяналтанд 35 эх хянагдаж байна. Артерийн гипертензия, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 75 хүнийг хамруулсан. “COVID-19” халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 28 байгууллага, 5450 хүнд хийж, худалдаа үйлчилгээ эрхлэн явуулдаг ААН, банкуудаар 3 удаа явж уг өвчний сэрэмжлүүлэг болон санамж хуудас гарын авлага тараасан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” 2020 оны А43 тушаалын дагуу сургуулийг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түр зогсоох шийдвэр гарсан. Сэлэнгэ аймгийн боловсрол соёл урлагийн газрын 2020.01.28-ны 56 тоот албан даалгаврын дагуу 2-р сарын 3-аас үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж байгаа теле хичээлүүдийг багш нар өөрсдөө үзэж, суралцагчдад цахим сүлжээ гар утас ашиглан чиглүүлэн заавар зөвлөгөө өгч дасгал даалгавар ажлуулж эхлээд 3 сар гаран хугацаа өнгөрсөн байна. Сурагчид сургалтын хөтөлбөрийн хүрээнд телевизээр тогтсон хуваарийн дагуу хичээлээ судалж байна. Алслагдсан болон зурагт үзэх боломжгүй байгаа сурагчдад нэмэлт даалгавар өгч байна. Аймгийн БСУГ-аас өгсөн чиглэлийн дагуу баасан гариг бүр нөхцөл байдлын мэдээг явуулж байна.

Мөн БСШУС-ын сайдын А220 тоот тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 5 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулж ажиллаж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг сахин биелүүлж байна. ЕБС-ийн 12 дугаар анги нь нийт 29 суралцагчидтай бөгөөд бүгд ЭЭШ-д бэлдэж байна. Суралцагчийн биеийн халууныг давтлага эхлэхээс 10 минутын өмнө үзэж, амны хаалтыг тогтмол зүүлгэж, гарыг нь ариутгаж, тлгтоосон дэгийг мөрдөн хуваарийн дагуу ажиллаж байна.

Хүдэр сум

Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Маскаа зүүцгээ” аяныг суманд зохион байгуулан ажиллаж байна. Уг аянд нэгдэхийг уриалж тус сумын ЗДТГ, Цэцэрлэг, ЕБС, ЭМТөв, Соёлын төв, 1, 2-р баг зэрэг байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар иргэдэд уриалж, сурталчилан ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэгийн хариуцлагатай жижүүр багш, ажилчдыг сумын төвд сайн дурын эргүүлээр ажиллуулах, хуваарийг гаргаж батлуулах шийдвэр гаргасаны дагуу 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн сургууль, цэцэрлэгийн хариуцлагатай жижүүр багш, ажилчид сумын төв, гэр хороолол, дэлгүүр, үйлчилгээний цэгүүдэд хяналт тавьж ажиллаж байгаа ба хүүхдүүдийг гадуур тэнэхгүй байх, дэлгүүр, үйлчилгээний газраар явахгүй байхад анхааран хяналт тавин ажиллалаа.

Төр төсвийн байгууллагын албан хаагчид иргэдийг уриалан цахим орчинд “Би амны хаалтаа тогтмол зүүдэг” мэссэж бүхий порфайл зургийг тавьж найзаа чөлленжид дуудах аянг энэ 7 хоногт эрчимтэй өрнүүлээ. Байгууллага бүр уг аянд нэгдэж оролцлоо.

Энэ сард сумын хэмжээнд нэгдсэн ариутгал халдваргүйтлийн ажлыг нийт 38 цэгийн 37768 м2 талбайд хийж гүйцэтгэсэн.

Сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж иргэдээс гомдол санал гаргалгүй ажиллаж байна. Тайлант сард эмнэлэгт хэвтсэн 11, ор хоног 63, төрсөн эх 1, нийт дуудлага 88, үүнээс алсын дуудлага 2, амбулаторийн 262 үзлэг хийсэн.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэр бүлийн харилцаанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүд эсвэл ажил хөдөлмөр эрхэлж гэр бүлийн санхүүгээ авч явдаг гэхчилэн ялгаваргүйгээр нэг цэгт нэг байр сууринд байх нь бэлгийн дарамтнаас урьдчилан сэргийлэх нэг алхам юм. Аймгийн цагдаагийн байгууллагаас санаачилсан “Хайр өвтөгдөггүй” аянд сумын 132 төрийн албан хаагч 56 иргэн нэгдэж байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөртсумаас 4 квотын хүрээнд Сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар оруулан Малжуулах төсөл хөтөлбөрт Ц.Оргил 4000,0 мянган төгрөг Н.Дашбалжир 5000,0 мянган төгрөг, Д.Нямочир 5000,0 мянган төгрөг, П.Базарсад 5000,0 мянган төгрөг, 36 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх гэрээ байгуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 19000,0 мянган төгрөгний санхүүжилтийг 4 малчин авсан байна.

МУ-ын Ерөнхий сайдын 01 албан даалгавар, Аймгийн Засаг даргын А/98, 110 дугаар захирамж, сумын Засаг даргын А/38 дугаар захирамжаар “Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйтгэлийн сарын аян”, “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд ажиллаж байна. Аяны хүрээнд түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг, зoorь 1080м², малын хашаа, хороо 23600м², худаг, уст цэг 400м², нийтийн эзэмшлийн талбай, албан байгууллага, машины зогсоол, сумын бохир усны цэвэрлэх байгууламж, үйлчилгээний газрын 10684м², сэг зэм 300м², өтөг бууц 26м² талбайд тус тус ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллаа.

Энэ онд 6 аж ахуйн нэгж тариалалтанд гарсан ба одоогийн байдлаар 3180 га-д улаанбуудай, арвай-100 га-д, овъёос 100 га-д, төмс 45 га-д тариалалт хийгээд байна. Нийт ногоочин өрхөд үрийн төмс, манжин, лууван, байцаа, улаан лооль, сонгино, сармис зэрэг үрүүдийг тарааж нийт 360 өрх хамарсан.

“Хаягжуулалтын тухай хууль”-ын дагуу шинэ хаягаар 21 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад кадастрын зургаар үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Мөн “Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль”-ын 7.1 дүгээр зүйлд заасны дагуу кадастрын зураг хийлгэх хүсэлт гаргасан 18 иргэдийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар болон үл хөдлөх эд хөрөнгөд кадастрын эрх бүхий байгууллагаар хэмжилт, зураглал хийлгэх захиалганд бүртгэн ажиллалаа.

Газар өмчлөх эрх үүссэн 8 иргэний хүсэлтийг хүлээн авч улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай материалыг бүрдүүлэн иргэдэд хүлээлгэн өглөө. Сумын Засаг даргын захирамжийн дагуу газар эзэмших эрх үүссэн 3 иргэний газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтийг хүлээн авч холбогдох материалыг аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-т илгээн эзэмших эрхийн гэрчилгээний дугаар авч 2 иргэн, аж ахуйн нэгжийн 1 нэгж талбарт гэрчилгээ, кадастрын зураг олгон газар эзэмших эрхийг баталгаажуулж гэрээ байгуулсан байна.

2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6-р сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ой хээрийг түймрээс хамгаалах зорилгоор Жалга, Сөдтэйн чиглэлд “Хяналтын цэг” ажиллуулж, төлөвлөгөө, хяналтын цэгт ажиллах хуваарь болон хөдөлгөөнт эргүүл шалгалт хийх хуваарийг гарган батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ойн экосистемийн доройтолд цаг уурын дулаарал, түймэр, хортон шавж, уул уурхай, бэлчээр талхлалт, хуулийн хэрэгжилт зэргээс гадна хүний хүчин зүйл маш ихээр нөлөөлж байна. Үүнийг сааруулах гол арга хэмжээ бол мод, бут тарьж ойжуулах, байгалийн ойгоо хамгаалах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах явдал юм. 2020онд ойгоос мод бэлтгэх хуваарьт орсон аж ахуй нэгж, нөхөрлөлүүдээс Хүдэр тамир ХХК 17 га, Хүдэр төгөл ХХК 1 га талбайд өөрийн хөрөнгийн ойжуулалт, нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 63 тоот зарлиг, аймаг, сумын Засаг даргын захирамжийн хүрээнд Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулж тухай төр төсвийн байгууллага болон ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуй нэгж байгууллага, иргэдийг хамруулан “ӨРХ БҮР 2 МОД ТАРЬЯ” уриан дор сургалт сурталчилгаа, зөвлөгөө мэдээлэл өгч, нийт 660 ширхэг мод бутыг тарьлаа.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 200 ширхэг гарын авлага, Хаврын улирал эхэлж хүрэн баавгай ичээнээс гарах хугацаа ойртсонтой холбогдуулж баавгайн халдлагаас урьдчилан сэргийлэх санамж 50 ширхэг, нийт 250 ширхэг гарын авлага зөвлөмжийг малчид, тариаланчидад хүргүүлэн ажилласан.

Хушаат сум:

Аймгаас зарласан “Иргэний хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд сумын шилдэг өрхүүдийг шалгаруулж, шагнаж урамшууллаа. Үүнд “Шилдэг ногоон байгууламжтай өрх”-өөр Мөнхтолгой багийн иргэн Д.Пүрвээгийн гэр бүл, “ Угийн бичгээ хөтөлдөг шилдэг өрх”-өөр Д.Оюуны гэр бүл, “ Эрүүл мэндээ хамгаалагч шилдэг өрх”-өөр Г.Мөнхбаярийн гэр бүл”, “ Үр хүүхдээ зөв хүмүүжүүлсэн шилдэг өрх”-өөр Ш.Алтанцэцэгийн гэр бүл, “Хорт зуршилгүй шилдэг гэр бүл”-ээр О.Алтангэрэлийн гэр бүл, “Шилдэг тохижилттой шилдэг өрх”-өөр Ш.Мажаасүрэнгийн гэр бүл тус тус шалгарсан.

Сумын ОХНС-ийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн ажлууд, 2012-2019 онд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын талаар видео бичлэг, мэдээллийг бэлтгэн цахим хуудаст байршуулж сурталчилсан.

"Таны дуу хоолой байгалиа хамгаалж чадна" аяны хүрээнд сумын ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан "Байгалиа хамгаалъя" сэдэвт гар зургийн уралдаанд нийт 15 сурагч оролцож 4а ангийн сурагч Х.Чингүүн тэргүүлж 4а ангийн сурагч Ц.Номин дэд байр, Н.Сувд-эрдэнэ 3-р байр, 3-а ангийн сурагч Г. Марал тусгай байрыг эзэллээ.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж бичгийг Хуучин төв, Могойт, Жаргалант, Бугат, Баянбулаг зэрэг газруудаар явж нийт 72 айл өрхөөр орж тараан гарын үсэг зуруулан баталгаа гаргуулан авлаа. Өгөөж Мандал Уул ХХК, Ойн стандарт ХХК, Ананд Марат ХХК –уудтай ойгоос мод шилжүүлэн суулгах гэрээ хийгдэж хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн төсөвт Ойны стандарт ХХК 2.0 сая төгрөг, Ананд Марат ХХК 1.0 сая төгрөгийг тус тус оруулсан байна.

Газар зохион байгуулалтын 2020 ний төлөвлөгөө ИТХ-ийн 2019.12.19-ний 03 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. КМСанд 8 нэгж талбар оруулж, Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэл рүү материалыг бүрдүүлж 8 иргэний гэрчилгээ бичиж, гэрээ байгуулсан ба 2 нь Э дугаар хүлээгдэж байна. Нийт 13 барьцаа бүртгэж цахим баржид оруулсан байна.

Авто тээврийн улсын үзлэг 2020 оны 05 дугаар сарын 12-нд тус суманд зохион байгуулагдсан. “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг тэмдэглэх ажлын хүрээнд “Миний мэдэх татвар” зохион бичлэгийн болон гар зургийн уралдаан зарлан явуулсан.

Сумын ЕБСургууль элсэлтийн ерөнхий шалгалтанд нийт 6 сурагч хамрагдаж байна. Сурагчдын биеийн халууныг үзэх, амны хаалт зүүлгэж, халууныг тогтмол үзэж тэмдэглэгээ хөтөлж амны хаалтыг 2 цаг тутамд солиулж, сольсон маскыг сургуулийн жижүүр нүх ухаж устгаж байна.

Сумын ЭМТ-д энэ сард нийт хийгдсэн үзлэгийн тоо бүгд 165, үүнээс амбулаторийн 95, урьдчилан сэргийлэх 25, идэвхитэй хяналт 20, гэрийн идэвхитэй үзлэг 25, хяналтанд байга жирэмсэн эх 21, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 54 байна. Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 80, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 80, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 23, шинжилгээнд хамрагдсан хүний тоо 60, умайн хавдар хөхний хавдар илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 40 байна.

Түшиг сум:

2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 3, аймгийн замын сангийн хөрөнгө

оруулалтаар хийгдэх зам засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ажил тус бүрээр байгуулан ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Онцгой комисс, шуурхай штабыг тогтмол ажиллуулж, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид өглөө бүр өөрсдийн хэрэглэж буй компьютер, ширээний тавцан, хаалга зэрэг газруудад жавелинтой цэвэрлэгээ хийж, албан хаагчид болон үйлчлүүлэхээр ирсэн иргэний бүрийг халууныг үзэж тэмдэглэгээ хийж байна.

Сумын Сонгуулийн хорооны тогтоолоор хэсгийн хороодыг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, сумын сонгуулийн хорооноос хэсгийн хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар сургалт явууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал-эрүүл ахуйн сарын аяны хүрээнд “Ажлын байран дахь хүчирхийлэл дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд төрийн албан хаагчдын дунд эссэ бичиг, гар зургийн уралдааныг зохион байгууллаа. Уралдааны эссэ бичигийн төрөлд 1-р байранд багш Л.Атарцэцэг, гар зургийн уралдааны 1-р байранд орон нутаг судлах танхимийн ажилтан Л.Халиун нар шалгарлаа.

Сумын дүнгээр улаан буудайн тариалалтын ажил 78 хувь, төл божилт 59 хувь, малын зүй бус хорогдол 0,9 хувьтай байгаа бөгөөд аймгийн Хөдөө аж ахуйн газраас олгогдсон төмс, хүнсний ногооны үрийг 30 өрхөд олголоо. Мөн иргэдээс төмсний үрийн захиалгыг авч гала сортын үрийн төмсийг 700 төгрөгөөр 40 өрхөд нийт 3,2 тн-ийг нийлүүллээ.

Сумын Эрүүл мэндийн төвд 18 хүнийг хэвтэн эмчлүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 1 эхийг шилжүүлэн төрүүлж, жирэмсний хяналтанд 2 эхийг шинээр авч, одоогийн байдлаар жирэмсний хяналтанд 20 эх байна. Осол гэмтлийн тохиолдол 4 бүртгэгдсэнээс дээд шатлалын эмнэлэгт 1 иргэнийг хүргэж, алсын 10, ойрын 18 дуудлагад үйлчиллээ. Артерын гипертензи 52, хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 61 хүнийг хамруулж, товлолт дархлаажуулалтанд 23 хүн/тун хийж, дархлаажуулалтын дараах урвал гараагүй.

Эрүүл мэндийн даатгалын 4 төрлийн хөнгөвчлөх үйлчилгээнд өдрийн эмчилгээнд 3, гэрийн үзүүлэх тусламж үйлчилгээнд 6, сэргээн засах 8, оношлогоо эмчилгээнд 13 хүнийг тус тус хамрууллаа.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг худалдаа үйлчилгээний газруудын мэдээллийн самбарт байршуулж, дотоодын сургалтыг 4 удаа зохион байгууллаа. Мөн давхардсан тоогоор төрийн болон төрийн бус, худалдаа үйлчилгээ, хилийн заставууд зэрэг 50 гаруй байгууллагын 5243м² талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийсэн.

2020-2021 оны хичээлийн жилд элсэн суралцах хүүхдийн бэлтгэлийг хангах талаарх зөвлөмжийг 36 эцэг, эхэд хүргэж, аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулсан “Багшдаа баярлалаа” сошиал хөдөлгөөнд байгууллага хамт олноороо нэгдлээ. Элсэлтийн ерөнхий шалгалтын онлайн сорилгод түүх, нийгмийн ухааны хичээлээр 10, монгол хэлний хичээлээр 12 сурагч өгсөн. Багш нар цахимаар сурагчдынхаа теле хичээлийн сургалтын явцтай тогтмол танилцаж, заавар зөвлөмж өгч байна.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА